

“ТӨРИЙН БАНК” ХУВЬЦААТ КОМПАНИ  
**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН**  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН МАТЕРИАЛ

2023.04.29



## АГУУЛГА

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар	4
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тогтоол	5
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын бүрэлдэхүүн	7
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хөтөлбөр	8
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудал:	10
<b>Танилцах асуудал</b>	
1. “Төрийн банк” ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн танилцуулга;	12
2. “Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах тухай танилцуулга;	32
3. “Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн гишүүдийн сонгон шалгаруулалтын үр дүнгийн талаарх танилцуулга.	34
<b>Хэлэлцэх асуудал</b>	
1. “Төрийн банк” ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батлах тухай тогтоолын төсөл;	36
2. “Төрийн банк” ХК-ийн хувьцааг нэмж гарган олон нийтэд санал болгох тухай тогтоолын төсөл;	40
3. “Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журамд өөрчлөлт оруулах тухай тогтоолын төсөл;	42
4. “Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын журам батлах тухай тогтоолын төсөл;	44
5. “Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ажиллах журам батлах тухай тогтоолын төсөл.	61
6. Саналын хуудасны загвар	73

## “ТӨРИЙН БАНК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ЗАР

“Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 41 дүгээр тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлаж байна.

- **Компанийн оноосон нэр:** “ТӨРИЙН БАНК” ХК
- **Хаяг:** Монгол улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу 7/1
- **Хурал болох газар:** Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Махатма Гандийн гудамж 39, Корпорэйт конвеншн центр, “Эвэнт холл” танхим
- **Хурал болох өдөр, цаг:** 2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 10:00 цаг /Хуралд танхимаар оролцох хувьцаа эзэмшигч хурал эхлэхээс 1 цагийн өмнө ирж бүртгэл хийлгэнэ/
- **Хурал болох хэлбэр:** Хосолсон /танхим болон зайнаас/  
Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр: 2023 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр

### ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

- **Танилцуулах асуудал:**
    1. “Төрийн банк” ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн танилцуулга;
    2. “Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах тухай танилцуулга;
    3. “Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн гишүүдийн сонгон шалгаруулалтын үр дүнгийн талаарх танилцуулга;
  - **Хэлэлцэх асуудал:**
    1. “Төрийн банк” ХК-ийн 2022 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батлах тухай тогтоолын төсөл;
    2. “Төрийн банк” ХК-ийн хувьцааг нэмж гарган олон нийтэд санал болгох тухай тогтоолын төсөл;
    3. “Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журамд өөрчлөлт оруулах тухай тогтоолын төсөл;
    4. “Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын журам батлах тухай тогтоолын төсөл;
    5. “Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ажиллах журам батлах тухай тогтоолын төсөл.
  - **Хувьцаа эзэмшигчдийн танилцах баримт бичгийн жагсаалт:**
    1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрийн төсөл;
    2. “Төрийн банк” ХК-ийн санхүүгийн жилийн тайлан;
    3. “Төрийн банк” ХК-ийн санхүүгийн жилийн тайлангийн талаарх аудитын байгууллагын дүгнэлт;
    4. Компанийн тухай хуулийн 65.6-д заасан шаардлагатай бусад бичиг баримт.
- Хувьцаа эзэмшигч Та 2023 оны 4 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн ажлын өдрүүдэд 10:00-17:00 цагийн хооронд өөрт тохиромжтой дараах газруудын аль нэгт эсхүл [/www.statebank.mn/](http://www.statebank.mn/) цахим хуудсаар дамжуулан хурлын материалтай танилцах боломжтой.
- Өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компани
  - “Төрийн банк” ХК-ийн төв байр Монгол улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу 7/1
  - Хурал зохион байгуулах комиссын утас: 75071881, цахим шуудан **[SBM\\_Shareholder@statebank.mn](mailto:SBM_Shareholder@statebank.mn)**

Хуралд танхимаар оролцох боломжгүй хувьцаа эзэмшигч Та урьдчилан санал өгөх боломжтой бөгөөд саналын хуудсыг бөглөн өөрийн үйлчлүүлдэг брокер дилерийн компаниар дамжуулан эсвэл Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо 7/1 хаягт байрлах “Төрийн банк” ХК-ийн Төв байр, орон нутаг дахь салбар нэгжүүдээр өгөх, эсхүл цахим хэлбэрээр Төрийн банкны цахим хуудас [/www.statebank.mn/](http://www.statebank.mn/)-аар дамжуулан өгөх ба саналын хуудсыг авах сүүлийн хугацаа 2023 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 15:00 цаг байна.



ЭРСДЛГҮЙ ИРЭЭДҮЙН БАТАЛГАА

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Огноо: 2023.03.17

№ 41

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан  
хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4 дэх хэсэг, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3 дахь хэсэг, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан Хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2023 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 10 цагт Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Махатма Гандийн гудамж 39, Корпорэйт конвеншн центр, Эвэнт холл-д хосолсон /танхим болон зайнаас/ хэлбэрээр зарлан хуралдуулсугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлах тухай мэдэгдлийг 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид тус тус хүргүүлэхийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга /Э.Уянга/-д даалгасугай.

3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг “Төрийн банк” ХК, Хөрөнгийн биржийн цахим хуудсаар болон өдөр тутмын хоёроос доошгүй сонин, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн дотор нийтэд мэдээлж, уг зарын давталтыг 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр анх зарласан хэлбэрээр дахин нийтэд мэдээлэхийг Гүйцэтгэх захирал /Ө.Гантөр/-д даалгасугай.

4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөр тогтоосугай.

5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гаргах шийдвэрийн төсөл, танилцуулга, саналын хуудас зэрэг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралтай холбогдох бусад баримт бичгийг 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдөрт багтаан үнэт цаасны брокер дилерийн компанид хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал /Ө.Гантөр/-д даалгасугай.

6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын нийтэд хүргэх зарын загварыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг 3 дугаар хавсралтаар баталсугай.

9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудасны загварыг 4 дүгээр хавсралтаар баталсугай.

10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулах Комиссыг 5 дугаар хавсралтад заасан бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын Комиссыг 6 дугаар хавсралтад заасан бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хосолсон хэлбэрээр зохион байгуулахад шаардлагатай цахим шийдлийг бүрдүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Ө.Гантөр/-д даалгасугай.

13. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материалтай танилцах боломжийг хувьцаа эзэмшигч бүрд олгох нөхцөлийг бүрдүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Ө.Гантөр/-д даалгасугай.

14. Хувьцаа эзэмшигчдийн саналыг урьдчилсан байдлаар 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 15 цаг хүртэл хугацаанд брокер дилерийн компаниар дамжуулан эсхүл Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо 7/1 хаягт байрлах "Төрийн банк" ХК-ийн төв байр, орон нутагт дахь салбар нэгжүүдэд цаасан болон цахим хэлбэр /www.statebank.mn/-ээр урьдчилан авах боломжийг бүрдүүлж ажиллахыг Зохион байгуулах комисс /Д.Сугар/-т даалгасугай.

15. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсыг цаасан болон цахим хэлбэрээр авч, нэгдсэн тооллогын үр дүнг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж, шийдвэрлүүлэхийг Тооллогын комисс /А.Батмөнх/-т даалгасугай.

16. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Сангийн дэд сайд /С.Мөнгөнчимэг/-ыг томилсугай.

17. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох бусад журамд заасан хугацаанд Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга /Э.Уянга/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.ТЭЛМҮҮН

"Төрийн банк" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
2023 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 44 дугаар  
тогтоолын 1.а дугаар хавсралт



## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИСС

**Комиссын дарга:**

Дотоод хяналт, шалгалтын газрын захирал А.Батмөнх

**Комиссын гишүүд:**

Эрсдэлийн удирдлагын газрын захирал Ц.Дамдинсүрэн

Хөрөнгө зохицуулалтын газрын захирал Д.Жадамбаа

Мэдээллийн технологийн газрын Хөгжүүлэлтийн хэлтсийн захирал

Б.Цэндсүрэн

**Комиссын нарийн бичгийн дарга:**

Харилцагчийн үйлчилгээний албаны менежер Л.Булгаа

## “ТӨРИЙН БАНК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХӨТӨЛБӨР

ХУГАЦАА	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХАРИУЦАХ
09.00-10.00	Хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийг бүртгэх	Зохион байгуулах комисс
10.00-10.05	Тооллогын комисс хурлын ирцийг танилцуулах	Тооллогын комисс А.Батмөнх
10.05-10.10	Хурлын үйл ажиллагааг нээх	Сангийн дэд сайд С.Мөнгөнчимэг
10.10-10.15	Хурлын хөтөлбөрийг танилцуулах	Сангийн дэд сайд С.Мөнгөнчимэг
10.15-10.25	“Төрийн банк” ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн танилцуулга хийх	Гүйцэтгэх захирал Ө.Гантөр
10.25-10.30	“Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах тухай танилцуулга хийх	ТУЗ-ийн дарга Б.Тэлмүүн
10.30-10.35	“Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн гишүүдийн сонгон шалгаруулалтын үр дүнгийн талаарх танилцуулга хийх	ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны дарга Д.Энхжаргал
10.35-10.40	Хурлаар хэлэлцэх асуудал бүрээр хэрхэн санал өгөх талаар дэлгэрэнгүй тайлбарлах	Тооллогын комисс А.Батмөнх
10.40-10.45	“Төрийн банк” ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батлах тухай тогтоолын төслийг хэлэлцэх	ТУЗ-ийн дарга Б.Тэлмүүн
10.45-11.05	Асуулт, хариулт, санал	Асуулт 2 минут, Хариулт 2 минут
11.05-11.15	“Төрийн банк” ХК-ийн хувьцааг нэмж гарган олон нийтэд санал болгох тухай тогтоолын төслийг хэлэлцэх	ТУЗ-ийн дарга Б.Тэлмүүн



ХУГАЦАА	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХАРИУЦАХ
11.15-11.35	Асуулт, хариулт, санал	Асуулт 2 минут, Хариулт 2 минут
11.35-11.40	“Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журамд өөрчлөлт оруулах тухай тогтоолын төслийг хэлэлцэх	ТУЗ-ийн дарга Б.Тэлмүүн
11.40-12.00	Асуулт, хариулт, санал	Асуулт 2 минут, Хариулт 2 минут
12.00-12.10	“Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын журам батлах тухай тогтоолын төслийг хэлэлцэх	ТУЗ-ийн дарга Б.Тэлмүүн
12.10-12.30	Асуулт, хариулт, санал	Асуулт 2 минут, Хариулт 2 минут
12.30-12.40	“Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ажиллах журам батлах тухай тогтоолын төслийг хэлэлцэх	ТУЗ-ийн дарга Б.Тэлмүүн
12.40-13.00	Асуулт, хариулт, санал	Асуулт 2 минут, Хариулт 2 минут
13.00-13.10	Санал хураалт	Тооллогын комисс
13.10-13.30	Завсарлага /Санал тоолох/	
13.30-13.35	Санал хураалтын дүнг нэгтгэн танилцуулах	Тооллогын комисс А.Батмөнх
13.35-13.45	Хурлын шийдвэрийг танилцуулж, хурлыг хаах	Сангийн дэд сайд С.Мөнгөнчимэг

“Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
2023 оны 3-р дугаар сарын 17-ны өдрийн 44 дугаар  
тогтоолын 1-р дугаар хавсралт



## **“ТӨРИЙН БАНК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ЖАГСААЛТ**

### **ТАНИЛЦАХ АСУУДАЛ:**

1. “Төрийн банк” ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн танилцуулга;
2. “Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах тухай танилцуулга;
3. “Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн гишүүдийн сонгон шалгаруулалтын үр дүнгийн талаарх танилцуулга;

### **ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:**

1. “Төрийн банк” ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батлах тухай тогтоолын төсөл;
2. “Төрийн банк” ХК-ийн хувьцааг нэмж гарган олон нийтэд санал болгох тухай тогтоолын төсөл;
3. “Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журамд өөрчлөлт оруулах тухай тогтоолын төсөл;
4. “Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын журам батлах тухай тогтоолын төсөл;
5. “Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ажиллах журам батлах тухай тогтоолын төсөл.

# **ТАНИЛЦАХ АСУУДАЛ**


---

# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАНИЛЦУУЛГА

---


1

## БАНКНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



Улаанбаатарын нэгж - 82  
 Орон нутгийн нэгж - 413

### Нийт ажилтан



● Төв    ● УБ нэгж    ● ОН нэгж


## ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ




**НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ  
КОМПАНИЙН ХЭЛБЭРТ  
АМЖИЛТТАЙ ШИЛЖЛЭЭ**




**АКТИВЫН ЧАНАРЫН  
ҮНЭЛГЭЭГЭЭР АМЖИЛТТАЙ  
ҮНЭЛЭГДЛЭЭ**



**PCI-DSS ОНСАЙТ  
АУДИТЫГ АМЖИЛТТАЙ  
ХИЙЛГЭЛЭЭ**



**"ЦАЛИНТАЙ ДАДЛАГАЖИГЧ  
ОЮУТАН ХӨТӨЛБӨР"-ИЙГ  
ХЭРЭГЖҮҮЛЖ ЭХЭЛЛЭЭ**



**"ХУРДАН СИСТЕМ"-ИЙГ  
НЭВТРҮҮЛЛЭЭ**



**COBIT АУДИТЫН ЗӨВЛӨМЖИЙГ  
ХЭРЭГЖҮҮЛЭН АЖИЛЛАЖ  
БАЙНА**

## АМЖИЛТУУД



ТОП-100 аж ахуй нэгжээс наймдугаарт, банкны салбарын шилдэг дөрвөн банкны нэгээр дахин шалгарлаа.



Монгол Улсын нийгэм эдийн засагт хувь нэмэр оруулан Сангийн яам, Татварын ерөнхий газрын талархлыг хүртэв.



“Дэлхийн мөнгөний долоо хоног 2022” аянд оролцож дэд байр эзлэн хүндэт цомын эзэн боллоо.


## БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төрийн банкны 2022 оны БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ нь Стратегийн тэргүүлэх 3 чиглэлийн дагуу 21 ҮНДСЭН ЗОРИЛТ дэвшүүлж, 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 92% буюу хангалттай үнэлгээтэй ажилласан байна.



## САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

### Нийт актив /сая төгрөг/




Төрийн банк сүүлийн гурван жилд нийт активаа дунджаар 8.1 хувиар нэмэгдүүлсэн.

### Активын өгөөж




Банкны активын өгөөж 2022 онд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.35 нэгж хувиар өсч 2.57 хувьд хүрсэн.

### Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө /сая төгрөг/




Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө тогтмол нэмэгдэж буй нь банкны үйл ажиллагаа өргөжин тэлж, зах зээлд эзлэх байр сууриа нэмэгдүүлж байгааг илэрхийлнэ.

### Нийт зээл /сая төгрөг/



Төрийн банк 2022 онд нийт давхардсан тоогоор 1,184,067 харилцагчдад 1,877.2 тэрбум төгрөгийн зээл олгосон байна.

### Татварын дараах ашиг/алдагдал /сая төгрөг/



Төрийн банкны сүүлийн гурван жилийн дундаж цэвэр ашгийн өсөлт 71 хувь байна.

### Өөрийн хөрөнгийн өгөөж




Банкны өөрийн хөрөнгийн өгөөж 2022 онд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.87 нэгж хувиар өсч 22.97 хувьд хүрсэн.




## ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Нийт өөрийн хөрөнгийн  
хүрэлцээний үзүүлэлт /CAR/



Өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцааг тогтмол ханган ажиллахын зэрэгцээ, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааг биелүүлэн ажиллаж байна.

Төлбөр түргэн гүйцэтгэх  
чадварын харьцаа /LIQ/



Монголбанкны шалгуур үзүүлэлтийг тогтмол ханган ажилласан төдийгүй бүлгийн дундажтай харьцуулсан үзүүлэлтүүд дунджаас дээгүүр үзүүлэлттэй байна.

## КОМПАНИЙН УДИРДЛАГЫН ЗАРДАЛ

Тайлант хугацааны турш Банкны захирлууд болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдэд олгосон нийт олговрын дүн:

Мянган төгрөгөөр	2022 он	2021 он
Цалин ба бусад тэтгэмж	790,898	2,051,986
Нийгмийн даатгалын шимтгэл	158,779	398,702
Бонус болон бусад тэтгэмжүүд	487,281	1,018,716
<b>Нийт</b>	<b>1,436,958</b>	<b>3,469,404</b>

Эх сурвалж: "Грант Торнтон Аудит" ХХК -ийн хөндлөнгийн аудитын тайлан

# ДУНДАЖ ДАВХАРГЫГ ДЭМЖИГЧ БАНК БОЛОХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

- 1** САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ
- 2** БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР
- 3** САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ, ЗӨВЛӨГӨӨ МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ

## САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ

### ХАДГАЛАМЖИЙН БҮТЭЭГДЭХҮҮН



**Эрүүл иргэн хадгаламж**  
Иргэдийг гэрээт эмнэлэгийн байгууллагуудаар эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хөнгөлөлттэй үнээр хамрагдах боломж бүхий бүтээгдэхүүн.



**Сургалтын хадгаламж**  
Гадаад дотоодын их дээд сургуулиудад суралцахаар төлөвлөж буй оюутан сурагчдад зориулж хамгийн өндөр хүүний өгөөжтэйгээр хуримтлал үүсгэх боломжтой бүтээгдэхүүн.



**Төвбэн малчны хадгаламж**  
Орон нутгийн иргэдэд орлогоо хуримтлуулж, сар бүр хадгаламжийн хүүгээр мөнгөө өсгөх, карт, цахим үйлчилгээ болон малчны зээлийг хөнгөлөлттэй нөхцөлөөр авах боломжийг бүрдүүлсэн бүтээгдэхүүн.




**Тэтгэврийн сан хадгаламж**  
Ажил олгогч, ажилтан, банк гурвалсан гэрээ байгуулж, харилцагчид ирээдүйн хувийн тэтгэврийн сан бий болгоход нь дэмжлэг зорилго бүхий бүтээгдэхүүн.

### ЗЭЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН



**Өрхийн бизнесийн зээл**  
Өрхийн орлогоо нэмэгдүүлэх, бизнес үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд зориулсан бүтээгдэхүүн.



**Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зээл**  
Зээлийн хэмжээ, хугацааг нэмэгдүүлж, зээлдэгчид тавигдах шаардлагыг уян хатан болголоо.



**Гарааны бизнесийн зээл**  
Инкубацийн үйлчилгээнд хамрагдсан гарааны бизнес эрхлэгч нарын үйл ажиллагааг дэмжихэд зориулсан бүтээгдэхүүн.



**Гялс зээл**  
Харилцагчийн бага дүнтэй санхүүгийн хэрэгцээг шуурхай хангах зорилготой бүтээгдэхүүн бөгөөд зээлийн хэмжээ, хугацааг нэмэгдүүлсэн.



**Боловсролыг дэмжих зээл:** Гадаад, дотоодын их дээд сургууль, коллеж, ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагад суралцагч болон суралцахаар төлөвлөж буй оюутан сурагчдад сургалтын төлбөр, дотуур байрны төлбөр, сургалтын хэрэглэгдэхүүн худалдан авахад зориулсан бүтээгдэхүүн.


### БАГЦ БҮТЭЭГДЭХҮҮН



**Гадаадад ажиллаж, амьдарч буй Монгол иргэдэд зориулсан багц бүтээгдэхүүн**



Хадгаламж, ОУ-ын карт, гялсбанк болон зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээг хамтад нь багцалж, орон сууцны урьдчилгаа төлбөрийн хуримтлал үүсгэх, улмаар орон сууцтай болох хүсэлтэй гадаадад ажиллаж, амьдарч буй Монгол иргэдэд зориулсан банкны багц бүтээгдэхүүн үйлчилгээ.



**Худалдааны зээлийн шугамын багц бүтээгдэхүүн үйлчилгээ:**



Гадаад болон дотоод худалдаа эрхэлдэг хуулийн этгээдэд эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийн хэрэгцээнд зориулж Бизнесийн зээлийн шугам болон Эх үүсвэргүй гадаад, дотоод баталгаа, мөн Эх үүсвэргүй импортын аккредитивийг багцлан олгох боломжтой бүтээгдэхүүн.

## БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

### Картын бүтээгдэхүүн



Хосолсон валюттай  
виза карт



Миний Монгол карт



Save green кредит карт

### Цахим болон бусад үйлчилгээ



→ 599,826

Гялсбанкны харилцагч



→ 6,420

Картаар үйлчлэгч  
байгууллага



→ 90

Киоск төхөөрөмж



→ 84,416

Иж бүрэн даатгал



→ 950

Ухаалаг ПОС

## САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ, ЗӨВЛӨГӨӨ МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ:

### Санхүүгийн боловсрол



Иргэд, олон нийтэд

- “Санхүүгийн боловсрол гэж юу вэ?”
- “Хуримтлалын ашиг тус”



Танхимаар

55,418 иргэн

Олон нийтийн  
сүлжээ

609,100 иргэн



Сэдэв:

“Даатгал”, “Санхүүгээ хэрхэн удирдах вэ”, “Хуримтлал”, “Орлого зарлагаа хэрхэн удирдах вэ”, “Зээл хэрэгтэй юу?”, “Залуу гэр бүлийн санхүү” ...

10 цуврал видео контент



### Инкубатор төв



Ажилтан

123

Сургагч багш

252



Бүх салбар  
нэгжээр



Инкубацын  
үйлчилгээ

6,453

бизнес эрхлэгч

Сургалт

- Бизнесийг удирдах арга Манлайлагчийн ур чадвар
- Брэндинг болон маркетинг
- Орлого зардлын бүртгэл
- Банкны бүтээгдэхүүн үйлчилгээ
- Бизнес төлөвлөгөө боловсруулал
- Эрсдэлийн удирдлага
- Санхүүгийн удирдлага

Олгосон зээл



223 харилцагч

7.0 тэрбум төгрөг




Хамтын ажиллагаа 6 байгууллага

ЖДУГ, МУХАУТ, Бэст хөтөлбөр, СЭЗИС,  
Гоолингоо ментор клуб, Эрүүл амьдралын жигүүр ТББ

### Идэвхжүүлэлтийн арга хэмжээ

“Харилцагчийн өдөрлөг-2022” арга хэмжээ

10 аймаг




## ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

### Тогтвортой хөгжлийн хүрээнд баримтлах бодлого, журам, бүтэц



“Төрийн банкны Байгаль орчин, нийгэм, засаглалын бодлого”, түүнийг хэрэгжүүлэх журмыг шинэчлэн баталлаа. Мөн тогтвортой хөгжлийн үйл ажиллагааг банкны бүхий л түвшинд хэрэгжүүлэх зорилго бүхий “Тогтвортой хөгжлийн хороо” болон “Тогтвортой хөгжлийн алба”-г шинээр байгуулж, Тогтвортой хөгжлийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг өргөжүүлэн, чиглэл тус бүрт анхааран ажиллаж байна.




Монголын Тогтвортой Санхүүгийн холбоо, Монголбанк, Олон улсын санхүүгийн корпорацитай хамтран “Тогтвортой санхүүжилтийн хэрэгжилтийн үнэлгээ”-г 2016 оноос жил бүр хийж ирсэн бөгөөд Төрийн банк ХК нь 2022 онд өмнөх оны үр дүнгээ ахиулан “А” буюу “Хангалттай” үнэлгээ авлаа.

### Тогтвортой хөгжилд чиглэсэн бүтээгдэхүүн, үйчилгээ



Төрийн банк системийн нөлөө бүхий банкуудаас хамгийн түрүүнд хувьцаагаа олон нийтэд нээлттэй санал болгож, засаглалын хувьд олон нийтийн компани болох эхлэлийг тавьсан. Хувьцаа гаргаж татан төвлөрүүлсэн 25.4 тэрбум төгрөгийг Тогтвортой хөгжилд чиглэсэн болон Нийгмийн дундаж давхаргад чиглэсэн бүтээгдэхүүн үйлчилгээг санхүүжүүлэхэд зарцуулав.




Эмэгтэйчүүдийг дэмжих зорилгоор Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зээлийн бүтээгдэхүүнийг анх 2020 онд зах зээлд нэвтрүүлсэн. Нийт 568 эмэгтэй бизнес эрхлэгчид 12.5 тэрбум төгрөгийн зээлийг олгож, тэдний бизнесийн санхүүжилтэд дэмжлэг үзүүлж, хувь нэмрээ оруулж байна.



Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд зориулсан Юнион Пэй карт гаргагч байгууллагын Travel Mate Asia хөнгөлөлт урамшуулалд хамрагдах боломжтой, аяллын “Save green” кредит картыг зах зээлд нэвтрүүллээ.



БОАЖЯ-тай хамтарсан “Байгальд ээлтэй хүүний хөнгөлөлттэй төсөл”-ийн зээлийг 39 зээлдэгчид 785 сая төгрөг, Тусгай хамгаалалттай бүс нутгийн “Орчны бүсийн зээлийн эргэлтийн сангийн зээлийг дамжуулан зээлдүүлэх” зээлийг 146 зээлдэгчид 1.4 тэрбум төгрөг тус тус олголоо.



Байгаль эхээ хамгаалах, хойч үеэ байгальд хайртай иргэн болгох зорилгоор Хүрээлэн төсөлтэй хамтарсан “Эко карт”-ыг 2020 онд зах зээлд гаргаснаас хойш борлуулсан карт бүрээсээ 1000 төгрөгийг “Хүрээлэн” төслийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зориулж, “Амьд ертөнцийн цуврал” нэвтрүүлгийн хорин дугаарыг үзэгчдийн хүртээл болголоо.



Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, агаар болон орчны бохирдлыг бууруулах зорилготой Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны зээлийн бүтээгдэхүүнийг 2020 онд зах зээлд нэвтрүүлсэн ба 2022 онд зээлийн нөхцөлийг сайжруулж эрчим хүчний хэмнэлтийн хувиас хамаарч зээлийн хүүг шатлан бууруулахаар тогтоолоо.



Гэр хороололд гал түлэхгүй, утаагүй, урсгал зардалгүй, дулаахан байх технологийн шийдлийг илүү сонирхолтой, шинэлэг хэлбэрээр таниулах зорилгоор “Дулаан хамгаалдаг байшин” контентыг МООД, Хайбрид хаус ХХК, Сакура проперти ХХК-ий хамт олонтой хамтран бэлтгэж 1.2 сая үзэгчид хүргэлээ.

## НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

### ХҮНДЭТГЭЛИЙН АЯН-2022

“Хүндэтгэлийн аян 2022” аяныг зохион байгуулж нийт салбар, нэгжээрээ дамжуулан 21 аймаг, долоон дүүрэгт амьдран суугаа хамгийн өндөр настай 155 ахмад харилцагчдадаа хүндэтгэл үзүүлэв.



### БҮХ НИЙТЭЭР МОД ТАРИХ ҮНДЭСНИЙ ӨДӨРТ ТӨРИЙН БАНК НЭГДЛЭЭ

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд Төрийн банкны хамт олон нэгдэж 7500 гаруй мод тарьж, арчилгаа хамгаалалтын ажлыг хариуцан ажиллаж байна.

### “ГЯЛС ЦЭВЭРЛЭГЭЭ”

Байгальд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах байгаль орчноо хамгаалах үйлсэд байгууллага, олон нийтийг уриалан “Байгальд ээлтэй Гялс цэвэрлэгээ” аяныг 2018 оноос хойш хэрэгжүүлж байна. Монгол Улсын 21 аймаг, 315 сум, Улаанбаатар хотын Туул гол, Сэлбийн голын сав газар, орон нутагт тухайн аймаг, сумын гол горхи, ундны усны сав газар зэрэг нийт 6000 орчим га газрыг цэвэрлэж 735 тонн, ойролцоогоор 400 орчим автомашин хог хаягдлыг цуглууллаа.



### “ОЮУНЛАГ ЗАЛУУСАА ДЭМЖЬЕ” АЯН

Төрийн банкнаас Монгол хүний оюуны чадамжийг Дэлхийд гайхуулж буй “Оюунлаг залуусаа дэмжих” аяны хүрээнд Монголын шатрын холбоо, Шатрын их мастер, Монгол Улсын Гавьяат тамирчин Ц.Батчулуун, Дэлхийн 3 удаагийн аварга, өсвөрийн шатарчин Д.Мөнхзултай хамтран ажиллаж байна.

### ЗӨВЛӨМЖ, МЭДЭЭЛЭЛ

Цаг уур, орчны шинжилгээний газартай хамтран харилцагчдадаа цаг агаарын болзошгүй тохиолдлоос урьдчилан сэргийлэх зорилгоор Гялсбанк аппликейшнээр мэдэгдэл хэсгээр нийт 52 удаагийн мэдээлэл хүргүүлээ.



# АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

---

2022.12.31

# АУДИТЛАГДСАН ТАЙЛАН



## “ГРАНТ ТОРНТОН АУДИТ” ХХК

Аудит, татвар, зөвлөх үйлчилгээний дэлхийн сүлжээний бие даасан фирм

# Хараат бус аудиторын дүгнэлт

Далай тауэр, 9 давхар,  
ЮНЕСКО гудамж - 31,  
Сүхбаатар дүүрэг,  
1 хороо Улаанбаатар  
14230, Монгол улс  
T + 976 70 110744  
+ 976 70 110799

Dalai Tower, 9 floor,  
UNESCO street - 31,  
Sukhbaatar District-1,  
Ulaanbaatar 14230,  
Mongolia  
T + 976 70 110744  
+ 976 70 110799

### “Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд

#### Зөрчилгүй дүгнэлт

Бид “Төрийн банк” ХК (цаашид “Банк”)-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх дараах санхүүгийн тайлангуудад (цаашид “санхүүгийн тайлан” гэх)-д аудит хийлээ. Үүнд:

- Ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй тайлан,
- Санхүүгийн байдлын тайлан,
- Өмчийн өөрчлөлтийн тайлан,
- Мөнгөн гүйлгээний тайлан болон
- Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй,
- Бусад тайлбар тодруулгууд.

Бидний дүгнэлтээр, “Төрийн банк” ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа *Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага* гэсэн хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн Олон улсын стандартын зөвлөлийн мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн зохих шаардлагуудын дагуу тус Банкнаас хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, зохистой гэж итгэж байна.

#### Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн үнэлэмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн тусдаа дүгнэлт гаргаагүй болно.



**Аудитын гол асуудал**

**Хүлээгдэж буй зээлийн алдагдлын хасагдуулга**

Үйлчлүүлэгчдэд олгосон зээлийн ач холбогдол болон үнэ цэнийн бууралтын үнэлгээнд үндэслэсэн таамаглалуудын субъектив байдлаас шалтгаалан хүлээгдэж буй зээлийн алдагдлын хасагдуулгыг аудитын гол асуудал гэж үзсэн. Олон янзын шийдэл, таамаглалыг ашиглах нь хүлээгдэж буй зээлийн алдагдлын хорондуулгыг ихээхэн ялгаатай үр дүнд хүргэж болох ба энэ нь Банкны санхүүгийн үр дүнд материаллаг нөлөө үзүүлж болзошгүй юм.

Үнэлэмжийн голлох хамрах хүрээ нь Банкны хүлээгдэж буй зээлийн алдагдлын загварт тусгагдсан СТОУС 9-ийн хэрэглээний дагуу үнэ цэнийн бууралтыг тодорхойлох шаардлагуудын тайлбар, зээлийн чанар буурах эрсдэлийн тодорхойлолт болон бизнесийн түншийн санхүүгийн байдал, хүлээгдэж буй ирээдүйн мөнгөн гүйлгээ, макро эдийн засгийн хүчин зүйлсийн хэтийн төлөв, хүлээгдэж буй зээлийн алдагдлын загварт зохих ёсоор тусгагдаагүй одоо болон цаашид тохиолдох гадаад хүчин зүйлсийг тусгах нэмэлт зүйлийг ашиглах хэрэгцээ зэрэг хүлээгдэж буй зээлийн алдагдлын загварт ашигласан таамаглалыг багтаасан.

**Аудитын гол асуудалд авсан хариу арга хэмжээ**

Үнэ цэнийн бууралтын аргачлалын хувьд бидний гүйцэтгэсэн аудитын горим дараах зүйлээс бүрдсэн:

- Бид Банкны СТОУС 9-д суурилсан үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сангийн бодлоготой танилцаж, түүнийг СТОУС 9-ийн шаардлагуудтай харьцуулалт хийсэн.
- Бид төлөвлөлтийг үнэлж, үнэ цэнийн бууралтын нөөцийг тодорхойлоход ашигласан өгөгдөлд хамаарах хяналтын үйл ажиллагааны үр нөлөөнд сорил хийсэн бөгөөд үүнд зээл үүсэх үед олж авсан ажил гүйлгээний мэдээлэл, дотоод зээлийн чанарын үнэлгээ, өгөгдөл хадгалалт, хүлээгдэж буй зээлийн алдагдлын загварт холбогдох интерфейсүүд багтсан болно.
- Бид төлөвлөлтийг үнэлж, хүлээгдэж буй зээлийн алдагдлын загварт хамаарах хяналтын үйл ажиллагааны үр нөлөөнд сорил гүйцэтгэсэн ба үүнд загвар боловсруулах, түүнийг батлах, түүнд тавих байнгын хяналт/баталгаажуулалт, загварын удирдлага, математикийн нарийвчлал зэрэг болно.
- Бид зээлийн эрсдэлийн өсөлтийг Банкнаас зүй зохистой, оновчтой тодорхойлсон эсэх болон үүнээс үүдэн гарах эрсдэлийг олон янзын үе шатанд ангилсан үндэслэлийг шалгасан.
- Эрсдэлд өртөх жишээний хувьд, бид Банкнаас авах арга хэмжээний үе шатыг зүй зохистой, оновчтой эсэхийг шалгасан.
- Бид Банкнаас мөрдсөн материаллаг загварчлалын таамаглал болон голлох загварчлалын таамаглалд чиглэсэн нэмэлт зүйлс ба загварчлалын таамаглалд өөрчлөлт оруулах нөхцөл байдалд үнэлгээ хийж, сорил гүйцэтгэсэн.
- Банкны удирдлагын хүлээгдэж буй зээлийн алдагдлын тооцоололд ашигласан таамаглалын хувьд, бид удирдлагатай уулзалт хийж, олон нийтэд нээлттэй мэдээллийг ашиглан таамаглалыг баримтаар нотлон баталгаажуулсан.
- Бид эрсдэлд өртөх жишээг шалгаж, зээлийн чанар буурах эрсдэлийг цаг тухайд нь тодорхойлох, эрсдэлийн хүлээгдэж буй алдагдлын тооцооллыг үнэлэх горимыг гүйцэтгэсэн.
- Бид онолын үндэслэлийн талаар мэдээлэл авч, мөрдсөн загварчлалын математикийн иж бүрэн байдалд сорил гүйцэтгэсэн.
- Гадаад нөөцөөс авсан өгөгдлийн хувьд, бид ийм өгөгдлийг сонгосон үйл явц, түүний банканд хамааралтай эсэх, эдгээр өгөгдөлд тавих хяналт, удирдлагын талаар мэдээлэл авсан;
- Бид тусгай мэдлэг шаардсан чиглэлд мэдээллийн технологийн мэргэжилтнүүдээ оролцуулсан (жишээ нь, өгөгдөл мэдээллийн найдвартай байдал, хүлээгдэж буй зээлийн алдагдлын загвар гэх мэт).
- Бид санхүүгийн тайлангийн тодруулгын үнэн зөв эсэхэд үнэлгээ хийсэн.





### *Онцлох асуудал*

2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр Банкны тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсон ба энэхүү хуулийн хүрээнд банкны системд нөлөө бүхий банк нь нээлттэй хувьцаат Банк, бусад банк нь хувьцаат Банк хэлбэртэй байхаар зохицуулалтуудыг тусгаж өгсөн бөгөөд ингэснээр банкны сайн засаглалыг хөгжүүлж, хувьцаа эзэмшлийн хэт төвлөрлийг бууруулан, олон нийтийн хяналтын тогтолцоог бий болгох, жижиг хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчдын эрхийг хамгаалах үүднээс банкны хувьцаа эзэмших аливаа этгээд, түүний холбогдох этгээдийн хувьд банкны нийт саналын эрхтэй хувьцааны хувь хэмжээ 20 хувиас хэтрэхгүй байхаас гадна банкны тогтолцоонд шударга өрсөлдөөнийг дэмжиж, зах зээлд ноёлох болон өрсөлдөөнд харш аливаа үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх боломж бүрдэх юм.

Банкны тухай хуульд орсон энэхүү нэмэлт өөрчлөлт болон УИХ-ын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн "Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай" 16 дугаар тогтоолын дагуу Төрийн банк нь 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр хувьцаагаа олон нийтэд танилцуулан, нийт 37.5 сая ширхэг, 250 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий энгийн хувьцааг буюу нийт хувьцааны 5 хувийг олон нийтэд нээлттэй худалдаж, ХК-ийн буюу нээлттэй Банкны статустай болсон.

### *Бусад асуудал*

"Төрийн банк" ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайланд "Эрнэт Энд Янг Монголия аудит" ХХК аудит хийсэн ба зөрчилгүй санал дүгнэлт өгсөн байна.

### *Бусад мэдээлэл*

Удирдлага бусад мэдээлэлд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл "Төрийн банк" ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх жилийн тайланд багтсан мэдээллээс бүрдэх ба харин санхүүгийн тайлан болон манай аудиторын тайланг багтаахгүй. Жилийн тайлан нь энэхүү аудиторын тайлан гарсан өдрөөс хойш бидэнд нээлттэй болно.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй бөгөөд бид аливаа хэлбэрээр баталгаажуулалтын дүгнэлт илэрхийлэхгүй.

Санхүүгийн тайланд бидний хийсэн аудиттай холбоотой бидний үүрэг хариуцлага бол дээр тодорхойлсон бусад мэдээлэл бидэнд нээлттэй болсон үед уншиж танилцах, ингэхдээ уг бусад мэдээлэл нь санхүүгийн тайлан эсвэл аудитаар бидний олж авсан мэдлэгтэй материаллаг хэмжээгээр харшилж байгаа эсвэл өөрөөр материаллаг байдлаар буруу илэрхийлэгдсэн эсэхийг авч үзэх юм.

### *Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага*

Банкны удирдлага эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэгтэй. Удирдлагын тодорхойлох энэхүү дотоод хяналт нь санхүүгийн тайланг аливаа алдаа эсвэл залилангийн улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай байдаг.

Удирдлага нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ Банкны үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах банкны чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Банкны санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.



### *Санхүүгийн тайлагналын аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага*

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайланг нь бүхэлдээ анги эсэх талаарх үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар оршин байгаа материаллаг алдаа зөрчлийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй.

Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

АОУС-ын дагуу аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх үзлийг баримтлан ажилладаг. Үүнд:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- Банкны дотоод хяналтын үр ашигтай байдалд санал дүгнэлт өгөх зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулах зорилгоор аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын үндэслэлтэй, байдлыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Банкны тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал Банк тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж, санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ, үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад олж илрүүлсэн дотоод хяналтын мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий удирдлагатай харилцдаг.

Бид хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудад нийцсэн гэдгээ засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдэд мэдэгддэг ба мөн бид тэдгээр хүмүүстэй бүх харилцаа холбоо болон шаардлагатай гэж үзвэл холбогдох хамгаалалт зэрэг бидний хараат бус байдлын хүрээнд бодолцож үзвэл зохих асуудлуудаар харилцдаг.



Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад чухал асуудлуудыг тодорхойлж тэдгээр асуудлаа аудитын гол асуудлууд гэж үздэг. Хууль, дүрэм журмаар аливаа асуудлыг олон нийтэд мэдээлэхийг хориглосон эсвэл тун ховор тохиолдолд аудиторын тайландаа аливаа асуудлаар харилцах нь тухайн харилцаанаас хүртэх олон нийтийн үр өгөөжөөс илүү сөрөг үр дагавартай учраас аудиторын тайландаа харилцахгүй байх нь зүйтэй гэж үзсэнээс бусад тохиолдолд тэдгээр асуудлыг аудиторын тайландаа тодорхойлдог.

Энэхүү Хараат бус аудиторын тайланг гаргахад оролцсон Гэрээт ажлын партнер нь Н.Эрдэнэцог болно.



  
Н.ЭРДЭНЭЦОГ  
ГЭРЭЭТ АЖЛЫН ПАРТНЕР

Огноо: 2023.03.10

## Ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2022 он	2021 он
Үр ашигт хүүний аргачлалаар бодсон хүүний орлого	6	396,145,491	363,500,188
Хүү болон түүнтэй адилтгах орлого	6	8,784,428	21,973,641
Хүү болон түүнтэй адилтгах зардал	6	(182,859,623)	(190,640,521)
<b>Цэвэр хүүгийн орлого</b>		<b>222,070,296</b>	<b>194,833,308</b>
Хураамж ба шимтгэлийн орлого	7	34,132,518	29,053,607
Хураамж ба шимтгэлийн зардал	7	(8,828,413)	(6,718,631)
<b>Хураамж ба шимтгэлийн цэвэр орлого</b>		<b>25,304,105</b>	<b>22,334,976</b>
Арилжааны цэвэр орлого	8	13,461,603	4,006,641
Үйл ажиллагааны бусад зардал	9	(2,559,306)	(17,541,753)
<b>Үйл ажиллагааны нийт орлого</b>		<b>258,276,698</b>	<b>203,633,172</b>
Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сангийн орлого/(зардал)	10	4,157,793	(32,012,890)
<b>Үйл ажиллагааны цэвэр орлого</b>		<b>262,434,491</b>	<b>171,620,282</b>
Ерөнхий удирдлагын зардал	11	(138,280,871)	(110,605,423)
<b>Татварын өмнөх ашиг</b>		<b>124,153,620</b>	<b>61,014,859</b>
Орлогын албан татварын зардал	12	(26,858,777)	(15,267,271)
<b>Тайлант жилийн ашиг</b>		<b>97,294,843</b>	<b>45,747,588</b>
Нэгж хувьцаанд ноогдох ашиг			
Нэгж хувьцаанд ногдох ашиг	30	0.129	257.0

## Ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан (үргэлжлэл)

Мянган төгрөгөөр	Тодруулга	2022 он	2021 он	
<b>Бусад дэлгэрэнгүй орлого:</b>				
<i>Дараагийн тайлант хувацаанд ашиг, алдагдлын тайлан руу дахин ангилагдах бусад дэлгэрэнгүй орлого – (татварын дараах):</i>				
	Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэгсэлийн бодит үнэ цэнийн цэвэр өөрчлөлт	30	(15,035,131)	(4,987,873)
<i>Дараагийн тайлант хувацаанд ашиг, алдагдлын тайлан руу дахин ангилагдахгүй бусад дэлгэрэнгүй орлого – (татварын дараах):</i>				
	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ	30	11,135	-
	Нийгмийн хөгжлийн сангийн зарцуулалт	30	(37,950)	(37,378)
	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>		<b>(15,061,946)</b>	<b>(5,025,251)</b>
	<b>Тайлант жилийн татварын дараах нийт дэлгэрэнгүй орлого</b>		<b>82,232,897</b>	<b>40,722,337</b>

Энэхүү Ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланг 20-с 99 дүгээр хуудсан дах уг санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болох тодруулгуудын хамт уншина.

## Санхүүгийн байдлын тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2022 оны 12 сарын 31	2021 оны 12 сарын 31
<b>Хөрөнгө</b>			
Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах	13	726,396,277	250,920,691
Бусад банк ба санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	14	231,538,852	28,534,316
Үүсмэл санхүүгийн хэрэгсэл	15	15,034,433	759,107
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	16	1,868,626,502	2,237,147,348
Санхүүгийн хөрөнгө оруулалт – арилжаалах зориулалттай	17	10,896,733	7,310,813
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө	17	128,002,947	80,844,572
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэгсэл	18	957,771,729	967,315,767
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өмчийн хэрэгсэл	18	120,466	118,385
Хорогдуулсан өртгөөр бүртгэх өрийн хэрэгсэл	18	68,223,496	67,786,597
Бусад хөрөнгө	19	18,279,807	21,266,799
Борлуулах зориулалттай хөрөнгө	20	12,894,113	6,762,299
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	21	2,848,500	2,364,878
Үндсэн хөрөнгө	22	118,046,524	115,918,630
Биет бус хөрөнгө	23	5,940,582	5,630,775
Ашиглах эрхтэй хөрөнгө	24	20,573	53,279
<b>Нийт хөрөнгө</b>		<b>4,164,641,534</b>	<b>3,792,734,256</b>

## Санхүүгийн байдлын тайлан (үргэлжлэл)

Мянган төгрөгөөр	Тодруулга	2022 оны 12 сарын 31	2021 оны 12 сарын 31
<b>Өр төлбөр</b>			
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	25	315,533,091	115,952,799
Рело хэлцэл	26	333,230,213	153,809,693
Харилцагчдын харилцах, хадгаламж	27	2,749,360,513	2,856,798,045
Үүсмэл санхүүгийн хэрэгсэл	15	2,288,265	1,549,920
Зээлээр авсан эх үүсвэр	28	234,934,137	252,376,321
Бусад өр төлбөр	29	26,360,480	15,847,976
Түрээсийн өглөг	24	197,130	234,557
Орлогын татварын өр төлбөр	12	1,196,135	4,865,246
Хойшлогдсон татварын өр төлбөр	12	5,334,391	2,815,761
<b>Нийт өр төлбөр</b>		<b>3,668,432,355</b>	<b>3,404,250,318</b>
<b>Банкны хувьцаа эзэмшигчидэд ногдох өөрийн хөрөнгө</b>			
Энгийн хувьцаа	30	188,774,063	178,000,000
Нэмж төлөгдсөн капитал	30	14,652,725	-
Бусад нөөц	30	14,215,779	29,368,212
Хуримтлагдсан ашиг		278,566,612	181,115,726
<b>Нийт өөрийн хөрөнгө</b>		<b>496,209,179</b>	<b>388,483,938</b>
<b>Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгө</b>		<b>4,164,641,534</b>	<b>3,792,734,256</b>

Энэхүү Санхүүгийн байдлын тайланг 20-с 99 дүгээр хуудсан дах уг санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болох тодруулгуудын хамт уншина.



Уг санхүүгийн байдлын тайланг 2023 оны 3 дугаар сарын 10-ны өдөр батлав:

Гүйцэтгэх захирал  
Ө.Гантөр

Санхүүгийн газрын захирал  
М.Гантуяа

## “ТӨРИЙН БАНК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

Төрийн банк нь 2022 оны санхүүгийн жилд 96,170 сая төгрөгийн ашигтай ажилласан тул “Төрийн банк” ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн.

Ногдол ашиг тараах ТУЗ-ийн шийдвэрт татварын дараах цэвэр ашгийн 50 хувийг нийт эргэлтэд байгаа 755,096,250 ширхэг энгийн хувьцаанд мөнгөн хэлбэрээр, нэгж хувьцаанд 63.68 (жаран гурван төгрөг жаран найман мөнгө) төгрөгөөр тооцож хувьцаа эзэмшигчдэд хуваарилахаар тогтсон. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тасалбар болгон тогтоож, зохицуулагч байгууллагаас хариу мэдэгдэл ирүүлснээс хойш 60 хоногийн дотор олгохоор шийдвэрлэсэн.

Банк нь ногдол ашиг хуваарилсны дараа Компанийн тухай хууль болон Банкны тухай хууль, Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа бөгөөд зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн биелэлтийн тоон үзүүлэлтийг доорх хүснэгтээр харуулав.

№	Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлт	Байвал зохих	2022.12.31 Биелэлт	Ногдол ашиг хуваарилсны дараа
1	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа	> 9%	24.36%	21.85%
2	Өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын харьцаа	> 12%	24.36%	21.85%
3	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт	> 25%	42.16%	40.62%
4	Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нэгж валютаар)	< (+ - 15%)	7.23%	9.09%
5	Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт)	< (+ - 30%)	8.17%	8.06%





## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Огноо: 2023.02.17

№ 21

Улаанбаатар хот

### Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалт, Банкны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3 дахь хэсэг, "Төрийн банк" ХК-ийн дүрмийн 10.13.7 дахь заалт, 24.1 дэх хэсэг, "Төрийн Банк" ХК-ийн "Ногдол ашгийн бодлого"-ын 3.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. "Төрийн Банк" ХК-ийн 2022 оны татварын дараах цэвэр ашгийн 50 /тавь/ хувийг нийт эргэлтэд байгаа 755,096,250 ширхэг энгийн хувьцаанд мөнгөн хэлбэрээр ногдол ашиг болгон хуваарилсугай.

2. Нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн дүнг 63.68 /жаран гурван төгрөг жаран найман мөнгө/ төгрөг байхаар тогтоосугай.

3. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.

4. Ногдол ашгийг "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-иар дамжуулан эрх бүхий байгууллагын зөвшөөрөл ирснээс хойш 60 хоногийн дотор олгохыг Гүйцэтгэх захирал /Ө.Гантөр/-д даалгасугай.

5. Ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор гаргаж, Санхүүгийн зохицуулах хороо болон "Монголын Хөрөнгийн бирж" ХК-д хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал /Ө.Гантөр/-д даалгасугай.

6. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг Төлөөлөн Удирдах зөвлөлийн дарга /Б.Тэлмүүн/-д даалгасугай.

7. Энэ тогтоолын хувийг Монголбанк, Санхүүгийн Зохицуулах хороо, "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-д тус тус хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал /Ө.Гантөр/-д даалгасугай.

8. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, биелэлтийг хангуулахыг Төлөөлөн Удирдах зөвлөлийн дарга /Б.Тэлмүүн/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.ТЭЛМҮҮН

## **“ТӨРИЙН БАНК” ХК-ИЙН ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ҮР ДҮНГИЙН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА**

“Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журмын 2.4.1 дэх заалтын дагуу Хяналтын зөвлөлийн гишүүний сонгон шалгаруулалтыг 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдрөөс 2023 оны 3 дугаар сарын 03-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулан ажиллалаа.

Сонгон шалгаруулалтад оролцохоор 5 эрэгтэй, 3 эмэгтэй буюу нийт 8 нэр дэвшигч материалаа тогтоосон хугацаанд ирүүлсэн. “Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны 2023 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 02 дугаар хурлаар Нэр дэвшигчдийн ирүүлсэн материалтай танилцахад, давхардсан тоогоор “Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журмын 2.2 дахь хэсэг, 2.2.1 дэх заалтад заасан шаардлагыг хангасан баримт ирүүлээгүй 7 нэр дэвшигч, 2.2.4 дэх заалтад заасан шаардлагыг хангасан баримт ирүүлээгүй 8 нэр дэвшигч, 2.2.3 дахь заалтад заасан шаардлагыг хангахгүй 2 нэр дэвшигч, 2.2.5 дахь заалтад заасан шаардлагыг хангахгүй 1 нэр дэвшигч тус тус материал ирүүлсэн байна.

Иймд “Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журамд заасан шаардлагуудыг бүрэн хангасан материал ирүүлсэн нэр дэвшигч байхгүй тул “Төрийн банк” ХК-ийн дүрэм, Хяналтын зөвлөлийн ажиллах журамд заасан Хяналтын зөвлөлийг байгуулах нөхцөл бүрдээгүй гэж дүгнэв.

**“ТӨРИЙН БАНК” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ДЭРГЭДЭХ НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО**

# **ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ**

---



ЭРСДЭЛГҮЙ ИРЭЭДҮЙН БАТАЛГАА

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Огноо: 2023.03.17

№ 42

Улаанбаатар хот

Төрийн банкны 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд дүгнэлт өгөх тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалт, Банкны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.5 дахь заалт, "Төрийн банк" ХК-ийн дүрмийн 10.13.15 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Төрийн банк" ХК-ийн 2022 оны бизнес болон санхүүгийн төлөвлөгөөний зорилтот түвшин хангагдсан гэж дүгнэсүгэй.

2. "Төрийн банк" ХК-ийн 2023 оны бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад дараах арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирал /Ө.Гантөр/-д даалгасугай. Үүнд:

2.1. "Төрийн банк" ХК-ийн актив пассивын зохистой удирдлагыг хангах, татан төвлөрүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх, банкны өдөр тутмын тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтын өндөр түвшинд ханган ажиллаж, төлөвлөгдсөн худалдан авах ажиллагааг тогтоосон хугацаанд хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахад анхаарах;

2.2. "Төрийн банк" ХК-ийн 2023 оны бизнес төлөвлөгөөнд тусгасан цахим шилжилт хийх, программ хангамжийн хөгжүүлэлтийн ажлын явцыг эрчимжүүлж, мэргэшсэн боловсон хүчний нөөц болон чадавхыг нэмэгдүүлэх;

2.3. "Төрийн банк" ХК-ийн 2023 оны бизнес төлөвлөгөөнд тусгагдсан чанаргүй зээлийг зорилтот түвшинд барьж ажиллах.

3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд банкны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулахыг Гүйцэтгэх захирал /Ө.Гантөр/-д, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны ажлын тайлан, Төрийн банкны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн дүгнэлтийг танилцуулж хэлэлцүүлэхийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга /Б.Тэлмүүн/-д тус тус даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.ТЭЛМҮҮН



## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Огноо: 2023.03.15

№ 39

Улаанбаатар хот

### Төрийн банкны 2022 оны аудитлагдсан санхүүгийн тайланд дүгнэлт өгөх тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалт, Банкны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.5 дахь заалт, “Төрийн банк” ХК-ийн дүрмийн 10.13.15 дахь заалт, “Грант Торнтон Аудит” ХХК-ийн санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлттэй танилцаад ТОГТООХ нь:

1. “Төрийн банк” ХК-ийн 2022 оны санхүүгийн тайланг материаллаг алдаагүй, хангалттай гэж дүгнэсүгэй.
2. Санхүүгийн тайлагналын Олон Улсын стандартын дагуу хөндлөнгийн аудитын тайланд тусгагдсан холбогдох гүйлгээг бүртгэхийг Гүйцэтгэх захирал /Ө.Гантөр/-д зөвшөөрсүгэй.
3. Хөндлөнгийн аудитын тайланд тусгагдсан зөвлөмжийг хэрэгжүүлэхтэй холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Гүйцэтгэх захирал /Ө.Гантөр/-д үүрэг болгосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд банкны аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг танилцуулж хэлэлцүүлэхийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга /Б.Тэлмүүн/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.ТЭЛМҮҮН

## **“ТӨРИЙН БАНК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ**

### **“Төрийн банк” ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.6, 29.2.7 дахь заалт, “Төрийн банк” ХК-ийн 2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Төрийн банк” ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг баталсугай.

2. “Төрийн банк” ХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд “Грант Торнтон Аудит” ХХК-ийн хийж баталгаажуулсан аудитын тайлан, түүний талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА

С.МӨНГӨНЧИМЭГ

## “ТӨРИЙН БАНК” ХК ХУВЬЦАА НЭМЖ ГАРГАХ ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

Төрийн банк нь Банкны тухай хуульд заасны дагуу нийт хувьцааны 5.71 хувийг олон нийтэд арилжаалж, нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжсэн.

УИХ-ын үндсэн чиглэл, Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн 130/А-191 тоот хамтарсан тушаалаар баталсан “Төрийн банкиг олон нийтэд нээлттэй хувьцаат компани хэлбэрт шилжүүлэх хөтөлбөр” нь Банкны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төрийн өмчит банкиг нэмж хувьцаа гарган биржээр нээлттэй арилжаалах замаар олон нийтийн хяналтад оруулах, санхүүгийн сахилга бат, засаглалыг сайжруулах, үйл ажиллагааны тогтвортой, ил тод байдлыг хангах зорилгоор батлагдсан бөгөөд тус үндсэн чиглэл, хөтөлбөрт 20 хүртэлх хувийг үе шаттайгаар олон нийтэд нээлттэй арилжаалахаар заасны дагуу банк 14.29 хүртэлх хувийн хувьцааг олон нийтэд санал болгохоор байна.

Олон нийтэд санал болгох 14.29 хувийн хувьцааг эзэмшүүлэхэд нэмж гаргах хувьцааны тоо хэмжээ болон хувьцаа эзэмшигчдийн бүтэц дараах байдалтай байхаар байна. Үүнд:

№	Хувьцаа эзэмшигч	Хувьцаа нэмж гаргахаас өмнө		Нэмж гаргах хувьцааны тоо		Хувьцаа нэмж гаргасны дараа	
		Эзэмших хувьцааны тоо ширхэг	Эзэмшлийн хувь	Эзэмших хувьцааны тоо ширхэг	Хувь	Эзэмших хувьцааны тоо ширхэг	Эзэмшлийн хувь
1	Сангийн яам	372,000,000	49.26%			372,000,000	41.80%
2	ХДК	340,000,000	45.03%			340,000,000	38.20%
3	Олон нийт	43,096,250	5.71%	134,903,750	14.29%	178,000,000	20.00%
НИЙТ ДҮН		755,096,250	100%	134,903,750	14.29%	890,000,000	100.00%

## “ТӨРИЙН БАНК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ

### Хувьцаа нэмж гаргах тухай

Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлтийн 29.1 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2.2 дахь заалт, 38 дугаар зүйлийн 38.8 дахь хэсэг, 42 дугаар зүйлийн 42.4 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.3, 62.1.8 дахь заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, УИХ-ын 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 16 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн өмчит банкны хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл”, Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 130/А-191 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Төрийн банкныг олон нийтэд нээлттэй хувьцаат компани хэлбэрт шилжүүлэх хөтөлбөр”, “Төрийн банк” ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5.3 дахь заалт болон “Төрийн банк” ХК-ийн 2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Төрийн банк” ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж, компанийн гаргасан 250 (хоёр зуун тавь) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 755,096,250 (долоон зуун тавин таван сая ерэн зургаан мянга хоёр зуун тавь) ширхэг энгийн хувьцаан дээр 250 (хоёр зуун тавь) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 134,903,750 (нэг зуун гучин дөрвөн сая есөн зуун гурван мянга долоон зуун тавь) ширхэг энгийн хувьцааг олон нийтэд санал болгохоор нэмж гаргасугай.

2. “Төрийн банк” ХК-ийн нэмж гаргаж буй 134,903,750 (нэг зуун гучин дөрвөн сая есөн зуун гурван мянга долоон зуун тавь) ширхэг хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг тус компанийн хувьцаа эзэмшигчдэд эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэсүгэй.

3. Нэмж гаргах энгийн хувьцааг “Монголын хөрөнгийн бирж” ХК-аар дамжуулан олон нийтэд нээлттэй арилжаалсугай.

4. Энэхүү тогтоолын дагуу нэмж гаргаж буй 134,903,750 (нэг зуун гучин дөрвөн сая есөн зуун гурван мянга долоон зуун тавь) ширхэг энгийн хувьцаа нь “Төрийн банк” ХК-ийн нийт гаргах энгийн хувьцааны 14.29 хувьтай тэнцэх бөгөөд анхдагч зах зээлийн арилжааг амжилттай зохион байгуулсны үр дүнд одоогийн хувьцаа эзэмшигч болон олон нийтийн эзэмших хувь дор дурдсанаар өөрчлөгдөхийг баталгаажуулсугай.

№	Хувьцаа эзэмшигч	Хувьцаа нэмж гаргахаас өмнө		Хувьцаа нэмж гаргасны дараа	
		Эзэмших хувьцааны тоо ширхэг	Эзэмшлийн хувь	Эзэмших хувьцааны тоо ширхэг	Эзэмшлийн хувь
1	Сангийн яам	372,000,000	49.26%	372,000,000	41.80%
2	Хадгаламжийн даатгалын корпораци	340,000,000	45.03%	340,000,000	38.20%
3	Олон нийт	43,096,250	5.71%	178,000,000	20.00%
НИЙТ ДҮН		755,096,250	100%	890,000,000	100.00%



5. Хувьцаа нэмж гаргахтай холбоотойгоор андеррайтер, аудит, үнэлгээ, хуулийн зөвлөх үйлчилгээний хуулийн этгээдүүдтэй гэрээ байгуулж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /Б.Тэлмүүн/-д үүрэг болгосугай.

6. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа асуудлыг тухай бүр холбогдох хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэн ажиллах бүрэн эрхийг Төлөөлөн удирдах зөвлөл /Б.Тэлмүүн/, Гүйцэтгэх захирал /Ө.Гантөр/-д олгосугай.

7. Энэхүү тогтоолын биелэлтийг хангаж, Санхүүгийн зохицуулах хороо, “Монголын Хөрөнгийн бирж” ХК-д нэмж гаргасан хувьцааг бүртгүүлэх, арилжаалах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах зэрэг шаардлагатай арга хэмжээг шуурхай зохион байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөл /Б.Тэлмүүн/, Гүйцэтгэх захирал /Ө.Гантөр/-д үүрэг болгосугай.

8. Нэмж гаргах хувьцааг зохих журмын дагуу олон нийтэд санал болгон “Монголын Хөрөнгийн бирж” ХК-аар амжилттай арилжаалсан тохиолдолд шаардлагатай асуудлыг хэлэлцүүлэхээр Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуульд заасан хугацаанд зарлан хуралдуулахыг Төлөөлөн удирдах зөвлөл /Б.Тэлмүүн/-д үүрэг болгосугай.

9. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /Б.Тэлмүүн/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

С.МӨНГӨНЧИМЭГ

## **“ТӨРИЙН БАНК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ**

### **“Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.16 дахь заалт, “Төрийн банк” ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5.12 дахь заалт, “Төрийн банк” ХК-ийн 2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журамд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалтыг нэмсүгэй:

1/2 дугаар зүйлийн 2.6 дахь хэсэг:

“2.6. Энэ журмын 2.4.4 дэх заалтад заасны дагуу Хяналтын зөвлөлийн гишүүний цалинг тогтоохдоо хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 (хоёр) дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээнээс илүүгүй хэмжээгээр тогтооно.”

2/2 дугаар зүйлийн 2.4.5 дахь заалт:

“2.4.5. Энэ журмын 2.4.3 дахь заалтад заасны дагуу нэр дэвшигч бүрээр дүгнэлт гаргахад Хяналтын зөвлөлийн гишүүний сонгон шалгаруулалтад нэр дэвшүүлэх хүсэлт ирээгүй, эсхүл Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч нь журмын 2.2 дахь хэсэгт заасан шаардлага хангахгүйн улмаас Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд нэр дэвшүүлэх Хяналтын зөвлөлийн гишүүний тоо 7 (долоо)-д хүрэхгүй тохиолдолд ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо сонгон шалгаруулалтын хугацааг 10 (арав) хоногоор сунгаж, хувьцаа эзэмшигчдэд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дахин мэдэгдэнэ.”

3/2 дугаар зүйлийн 2.4.6 дахь заалт:

“2.4.6. Энэ журмын 2.4.5 дахь заалтад заасны дагуу сунгасан сонгон шалгаруулалтын хугацаанд нэмэлт хүсэлт ирээгүй, эсхүл Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч нь журмын 2.2 дахь хэсэгт заасан шаардлага хангахгүйн улмаас Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд нэр дэвшүүлэх Хяналтын зөвлөлийн гишүүний тоо 7 (долоо)-д хүрэхгүй тохиолдолд ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо сонгон шалгаруулалтыг хүчингүйд тооцож, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулна.”

4/2 дугаар зүйлийн 2.4.7 дахь заалт:

“2.4.7. Энэ журмын 2.4.6 дахь хэсэгт заасны дагуу ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо сонгон шалгаруулалтыг хүчингүйд тооцсон тохиолдолд Хяналтын

зөвлөлийн гишүүнийг Хувьцаа эзэмшигчдийн дараагийн ээлжит хуралд нэр дэвшүүлэх сонгон шалгаруулалтыг явуулна.”

2. “Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журмын 4 дүгээр зүйлийн 4.11 дэх хэсгийн “тэмдэглэлд” гэсний дараа “хуралд оролцсон” гэж, мөн зүйлийн 4.10.4 дэх заалтын “шийдвэрийг” гэсний дараа “хуралд оролцож буй” гэж тус тус нэмсүгэй.

3. “Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журмын 2 дугаар зүйлийн 2.4.1 дэх заалтын “80 (ная)” гэснийг “100 (зуу)” гэж, мөн зүйлийн 2.4.3 дахь заалтын “50 (тавь)” гэснийг “70 (дал)” гэж тус тус өөрчилсүгэй.

4. “Төрийн банк ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарсан шийдвэрийг холбогдох эрх бүхий байгууллагад, нээлттэй мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд тус тус хүргүүлэхийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга /Э.Уянга/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

С.МӨНГӨНЧИМЭГ

## **“ТӨРИЙН БАНК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ЖУРАМ**

### **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1. Энэхүү журмаар “Төрийн банк” /ХК цаашид “банк” гэх/-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал /цаашид “ХЭХ” гэх/-ыг хуралдуулах шийдвэр гаргах, хурлын зарыг зарлан мэдээлэх, хурлын бэлтгэлийг хангах, зохион байгуулах, хурал хуралдах журмыг тогтоох болон бусад харилцааг зохицуулна.
- 1.2. ХЭХ-ыг Банкны тухай хууль, Компанийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон эрх бүхий байгууллагаас батлан гаргасан хүчин төгөлдөр бүхий эрх зүйн баримт бичигт заасны дагуу зохион байгуулна.

### **ХОЁР. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ**

- 2.1. “Төрийн банк” ХК-ийн эрх барих дээд байгууллага нь ХЭХ болно.
- 2.2. ХЭХ Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэгт зааснаас гадна банкны дүрэмд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
- 2.3. Хувьцаа эзэмшигчдийн хурал ээлжит болон ээлжит бус байна.
- 2.4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас бусад бүх хурал нь Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал байна.
- 2.5. ХЭХ-ыг танхим, цахим болон хосолсон (цахим, танхим) хэлбэрээр зохион байгуулж болно.
- 2.6. ХЭХ-ыг цахим болон хосолсон хэлбэрээр зохион байгуулахдаа Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Хувьцаат компанийн ХЭХ-ын зар хүргэх журамд заасан нөхцөл, шаардлагыг хангасан байна.
- 2.7. ХЭХ-ын эрх мэдлийн хүрээний асуудлыг хуульд зааснаас бусад тохиолдолд ТУЗ, Гүйцэтгэх захирал төлөөлөн хэрэгжүүлэхийг хориглоно.
- 2.8. ХЭХ-ын бэлтгэл хангахад банкны гүйцэтгэх удирдлага болон эрх бүхий албан тушаалтан дэмжлэг үзүүлэх, шаардлагатай мэдээ, мэдээллээр шуурхай хангах үүрэгтэй.
- 2.9. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.

## **ГУРАВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ШИЙДВЭР ГАРГАХ**

- 3.1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/ Компанийн тухай хуульд заасан хугацаанд буюу санхүүгийн жил дууссанаас хойш 4 (дөрөв) сарын дотор жилд нэг удаа зарлан хуралдуулна.
- 3.2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасан журмын дагуу дараах тохиолдолд зарлан хуралдуулна. Үүнд:
  - 3.2.1. ТУЗ ХЭХ-ыг зарлан хуралдуулах тухай шийдвэр гаргасан;
  - 3.2.2. ТУЗ-ийн нийт гишүүний 50 (тавь)-аас дээш хувь нь ажиллах боломжгүй буюу ажиллахгүй болсон;
  - 3.2.3. ТУЗ-ийн 2 (хоёр) буюу түүнээс дээш тооны хараат бус гишүүн, эсхүл саналын эрх бүхий хувьцааны 10 (арав) буюу түүнээс дээш хувийн хувьцааг дангаар эзэмшигч санал, шаардлага гаргасан;
  - 3.2.4. Банкны алдагдал тухайн тайлант үеийн эцэст өөрийн хөрөнгийн 30 (гуч) хувиас хэтэрсэн;
  - 3.2.5. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооноос хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хийхийг шаардсан;
  - 3.2.6. Банкны тухай хууль тогтоомжийн дагуу Монголбанкнаас албадлагын арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа тохиолдолд шаардлагатай гэж үзвэл Монголбанк, түүний томилсон бүрэн эрхт төлөөлөгч зарласан;
  - 3.2.7. Хувьцаа эзэмшигчид нэгдэн нийт саналын эрх бүхий хувьцааны 10 (арав) буюу түүнээс дээш хувийг бүрдүүлж, санал гаргасан;
  - 3.2.8. Банкны тухай хууль, Компанийн тухай хууль болон дүрэмд заасан бусад тохиолдол.
- 3.3. Энэ журмын дүрмийн 3.2.3, 3.2.7 дахь хэсэгт заасан этгээд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай санал, шаардлагыг ТУЗ-д гаргах эрхтэй.
- 3.4. Энэ журмын 3.3 дахь хэсэгт заасан санал, шаардлагыг бичгээр гаргах бөгөөд түүнд санал, шаардлага гаргасан хувьцаа эзэмшигчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, ээлжит бус хурал хуралдуулах болсон шалтгаан, хэлэлцэн шийдвэрлэх асуудал, хурлаас гаргах шийдвэрийн төсөл, өөрийн эзэмшиж байгаа хувьцааны төрөл, тоог заана.
- 3.5. ТУЗ хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулах тухай санал, шаардлагыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын арав (10) өдөрт багтаан хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах эсэх талаар шийдвэр гаргана.
- 3.6. ТУЗ дараах тохиолдолд ХЭХ хуралдуулахаас татгалзах шийдвэр гаргах бөгөөд уг шийдвэрийн үндэслэлийн талаар энэ журмын 3.3 дахь хэсэгт заасны дагуу санал, шаардлага гаргасан хувьцаа эзэмшигчид нэн даруй мэдэгдэнэ. Үүнд:
  - 3.6.1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай шаардлага гаргасан хувьцаа эзэмшигчийн саналын эрх нь нийт саналын эрхийн 10 (арав) хувьд хүрээгүй;

- 3.6.2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэхээр санал болгож байгаа асуудал нь ХЭХ-ын бүрэн эрхэд хамаарахгүй.
- 3.7. Энэ журмын 3.3 дахь хэсэгт заасны дагуу санал, шаардлага гаргасан хувьцаа эзэмшигч ХЭХ-ыг хуралдуулахаас татгалзсан ТУЗ-ийн шийдвэрийн талаар шүүхэд гомдол гаргаж болно.
- 3.8. Энэ журмын 3.5 дахь хэсэгт заасан хугацаанд ТУЗ шийдвэр гаргаагүй тохиолдолд санал, шаардлага гаргасан хувьцаа эзэмшигч, эсхүл ТУЗ-ийн хараат бус гишүүн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай шийдвэрийг бие даан гаргаж болно.
- 3.9. ТУЗ энэ журмын 3.5 дахь хэсэгт заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай шийдвэр гаргасан тохиолдолд санал, шаардлага хүлээн авсан өдрөөс хойш 45 (дөчин тав) хоног /тус хугацааг тогтоохдоо нийтээр тэмдэглэх баярын өдөр болон 7 (долоо) хоногийн амралтын өдрийг оролцуулахгүйгээр тооцож тогтооно/-ийн дотор тухайн хурлыг хуралдуулна.
- 3.10. ХЭХ хуралдуулахтай холбогдсон зардлыг банк хариуцна.
- 3.11. ХЭХ хуралдуулах тухай шийдвэр нь хууль тогтоомж болон Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан хувьцаат компанийн ХЭХ-ын зар хүргэх журамд нийцсэн байна.
- 3.12. ХЭХ хуралдуулах шийдвэр гарснаас хойш Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан хувьцаат компанийн ХЭХ-ын зар хүргэх журмын дагуу 5 (тав) хоногийн дотор ХЭХ-ын зарыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хувьцаа эзэмшигчид хүргэнэ.
- 3.13. ХЭХ хуралдуулах тухай шийдвэрт дараах зүйлийг заана. Үүнд:
- 3.13.1. Хурал хуралдуулах газар, өдөр, цаг;
  - 3.13.2. Хурлын хэлэлцэх асуудал;
  - 3.13.3. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр;
  - 3.13.4. Хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчид мэдэгдэх өдөр, журам;
  - 3.13.5. Хуралд бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт, хувьцаа эзэмшигчид хүргэх мэдээлэл, мэдээлэл хүргэх журам;
  - 3.13.6. Хэлэлцэх асуудал тус бүрээр санал өгөх эрх бүхий энгийн болон давуу эрхийн хувьцааны ангилал;
  - 3.13.7. Саналын хуудсаар санал авах бол саналын хуудасны агуулга;
  - 3.13.8. Саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдөр, хаяг;
  - 3.13.9. Хурлын дарга;
  - 3.13.10. Тооллогын комиссын дарга, гишүүд;
  - 3.13.11. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх зарын загвар
  - 3.13.12. ХЭХ-ыг зохион байгуулах комисс

- 3.14. Энэ журмын 3.13.9 дэх заалтад заасан хурлын дарга хүндэтгэн үзэх шалтгааны улмаас ХЭХ-ыг даргалах боломжгүй болсон тохиолдолд энэ тухайгаа ТУЗ-д мэдэгдэх ба ТУЗ хурлын даргыг хурал болохоос өмнө дахин томилно.
- 3.15. ХЭХ хуралдуулах тухай шийдвэр гарснаас хойш хурлын товд өөрчлөлт оруулахыг хориглоно.
- 3.16. Энэ журмын 3.13.12 дахь заалтад заасан ХЭХ зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнд банкны гүйцэтгэх удирдлага, ТУЗ-ийн дэргэдэх Засаглалын алба, Дотоод аудитын газар болон банкны эрх бүхий албан тушаалтнуудыг оролцуулна.

### **ДӨРӨВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ЗАР ХҮРГЭХ**

- 4.1. ХЭХ зарлаж байгаа этгээд ХЭХ-ын мэдэгдлийг хавсралт материалын хамт Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллагад ХЭХ хуралдуулах шийдвэр гарснаас хойш 3 (гурав) хоногийн дотор тус тус хүргүүлнэ.
- 4.2. ХЭХ-ын мэдэгдэл, зарыг хүргэхдээ Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "Хувьцаат компанийн ХЭХ-ын зар хүргэх, хяналт тавих журам"-д заасан нөхцөл, шаардлагыг хангасан байна.
- 4.3. Компанийн тухай хуулийн 60.4 дэх хэсэгт заасны дагуу хурлыг зарлан хуралдуулах шийдвэрийг гарснаас хойш 5 (тав) хоногийн дотор хурлын зарыг нийтэд мэдээлнэ.
- 4.4. ХЭХ-ын зарыг хурал хуралдахаас 30 (гуч) болон түүнээс багагүй хоногийн өмнө олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгээр болон компани, арилжаа эрхлэх байгууллагын цахим хуудсаар дамжуулан 2 (хоёр) ба түүнээс дээш удаа хувьцаа эзэмшигчдэд мэдээлнэ.
- 4.5. Энэ журмын 4.3 дахь хэсэгт заасан мэдээг мэдээлсэн өдрөөс хойш 15 (арван тав) хоногийн дараа олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгээр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлнэ.
- 4.6. ХЭХ-ын зарыг энэ журмын 4.3 дахь хэсэгт зааснаас гадна утас, факс, электрон шуудан зэрэг холбоо харилцааны боломжит бусад хэрэгслийг ашиглан хувьцаа эзэмшигчдэд хүргэж болно.
- 4.7. ХЭХ-ын зард дараах мэдээллийг заавал тусгана. Үүнд:
  - 4.7.1. Банкны оноосон нэр, байршил, хурал хийх өдөр, цаг, газар;
  - 4.7.2. ХЭХ-д оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр;
  - 4.7.3. ХЭХ-аар хэлэлцэх асуудлын жагсаалт;
  - 4.7.4. ХЭХ-аас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам, газар, ажиллах цаг;
  - 4.7.5. ХЭХ зохион байгуулах комиссын дарга, гишүүдийн утас, электрон шуудангийн хаяг, ажиллах цагийн хуваарь;

- 4.7.6. Банкны дүрэмд заасан болон хурал зарлагч этгээдээс шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл.
- 4.8. Компанийн тухай хууль болон банкны дүрэмд заасан хурлын ирц хүрээгүй тохиолдолд энэ тухай тэмдэглэл, протокол үйлдэж, хойшлогдсон хурлын товгыг тогтоож, хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг гарган хурлыг хойшлуулна. Хурал хойшлогдсон тухай мэдэгдлийг холбогдох материалын хамт Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад ажлын 4 (дөрөв) өдөрт багтаан тус тус хүргүүлнэ.

### **ТАВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛД ОРОЛЦОХ, ХУРЛЫН БАРИМТ БИЧИГТЭЙ ТАНИЛЦАХ ЭРХ**

- 5.1. ХЭХ-д оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг ТУЗ-өөс тогтоосон бүртгэлийн өдрөөр тасалбар болгон банкны үнэт цаас эзэмшигчдийн бүртгэлийг хөтлөх эрх бүхий этгээдээс авч, тухайн хурал зарласан этгээдэд хүргүүлнэ.
- 5.2. Бүртгэлийн өдрийг ТУЗ-ийн зүгээс ХЭХ-ыг хуралдуулах тухай шийдвэр гаргахад тогтоох бөгөөд энэ өдөр нь хурал хуралдуулах тухай зарыг нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 15-20 дахь өдөр байхаар тогтооно.
- 5.3. Бүртгэлийн өдрийг ХЭХ хуралдуулах тухай шийдвэр болон хувьцаа эзэмшигчдийн хурлын зард заана.
- 5.4. ХЭХ-д оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт нь хувьцаа эзэмшигч бүрийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, түүний эзэмшлийн хувьцааны төрөл, тооны талаарх мэдээллийг агуулсан байна.
- 5.5. Банк нь ХЭХ-д оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг банкны энгийн хувьцааны 10 (арав) буюу түүнээс дээш хувийг эзэмшигч этгээдийн шаардсанаар түүнд танилцуулах үүрэгтэй бөгөөд бусад тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтад байгаа хувьцаа эзэмшигч хэн болох тухай мэдээлэл болон тэдний шуудангийн хаягийг тухайн хүний зөвшөөрөлгүйгээр бусдад танилцуулж үл болно.
- 5.6. ТУЗ хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг хөтлөх эрх бүхий этгээдийн бичгээр ирүүлсэн зөвшөөрлийг үндэслэн ХЭХ-д оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлд өөрчлөлт оруулна.
- 5.7. Хувьцаа эзэмшигч нь ХЭХ-д өөрийн биеэр буюу Иргэний хуульд заасны дагуу бичгээр олгосон итгэмжлэлийн үндсэн дээр өөр этгээдээр төлөөлүүлэн оролцож болно.
- 5.8. Энэ журмын 5.7 дахь хэсэгт заасны дагуу төлөөлөн оролцох итгэмжлэгдсэн төлөөлөгч энэ тухайгаа ХЭХ эхлэхээс өмнө ТУЗ-д мэдэгдэх бөгөөд түүний итгэмжлэл нь гагцхүү тухайн хуралд хүчинтэй байна.
- 5.9. ТУЗ-өөс ХЭХ-ыг хойшлуулсан боловч тухайн хурлаар хэлэлцэхээр товлосон асуудлыг



өөрчлөөгүй тохиолдолд энэ журмын 5.7 дахь хэсэгт заасан итгэмжлэл дараагийн хуралд хүчинтэй байна.

- 5.10. Саналын хуудсаар саналаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчийг ХЭХ-д оролцсонд тооцно.
- 5.11. Бүртгэлийн өдрөөс хойш хувьцаагаа бусдад шилжүүлсэн этгээд шинэ эзэмшигчид ХЭХ-д оролцох итгэмжлэл олгох, эсхүл шинэ эзэмшигчийн өгсөн зааврын дагуу санал өгч болно.
- 5.12. Банкны нэгж хувьцааг хэд хэдэн этгээд дундаа хэсгээр өмчилж байгаа тохиолдолд ХЭХ-д оролцож санал өгөх эрхийг дундаа хэсгээр өмчлөгчдийн харилцан тохиролцсоноор хэн нэг нь, эсхүл тэдний төлөөлөгч хэрэгжүүлнэ.
- 5.13. Энэ журмын 5.12 дахь хэсэгт заасны дагуу төлөөлөн оролцох эрхийг Иргэний хуульд заасны дагуу баталгаажуулсан байна.
- 5.14. Дараах эрх бүхий этгээд ХЭХ-д оролцоно:
  - 5.14.1. Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтад орсон хувьцаа эзэмшигч болон тэдний эрх бүхий төлөөлөл;
  - 5.14.2. Гүйцэтгэх удирдлага, банкны захирлууд, хөндлөнгийн аудитор;
  - 5.14.3. ТУЗ-ийн гишүүд;
  - 5.14.4. Тооллогын комиссын гишүүд;
  - 5.14.5. ХЭХ-ын даргын зөвшөөрлөөр ТУЗ-д нэр дэвшиж байгаа саналын хуудсанд бичигдсэн этгээд;
  - 5.14.6. ХЭХ-ын даргын зөвшөөрлөөр ТУЗ-ийн дарга болон гүйцэтгэх захирлын урьсан холбогдох бусад этгээд.
- 5.15. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах үед хувьцаа эзэмшигчид дараах баримт бичигтэй танилцах бололцоог олгоно.
  - 5.15.1. Банкны санхүүгийн жилийн тайлан;
  - 5.15.2. Санхүүгийн жилийн тайлангийн талаарх аудитын байгууллагын дүгнэлт;
  - 5.15.3. Тайлангийн хугацаанд банкнаас байгуулсан сонирхлын зөрчилтэй хэлцлүүдийн жагсаалт болон тэдгээр хэлцлийг Банкны тухай хуулийн арван хоёрдугаар бүлэгт заасан журмын дагуу хийсэн эсэх тухай аудитын байгууллагын дүгнэлт;
  - 5.15.4. Банкны ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшсэн хүний тухай танилцуулга;
  - 5.15.5. Банкны нэгдмэл сонирхолтой этгээд, түүний эзэмшлийн хувьцааны төрөл, тоо;
  - 5.15.6. Банкны ТУЗ, гүйцэтгэх удирдлагын зардал, цалин, урамшуулал;
  - 5.15.7. Бизнесийн үйл ажиллагааны тайлан;
  - 5.15.8. Хэлэлцэх асуудалтай холбогдсон хувьцаа эзэмшигчдийн зайлшгүй мэдэх шаардлагатай бусад мэдээлэл.

- 5.16. Хурлаар банкны хувьцааг эргүүлэн худалдаж авах шаардлага тавих эрхтэй холбогдсон асуудлыг хөндөх бол ХЭХ-ын бэлтгэл ажлын явцад ХЭХ-д оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд тараах нэмэлт мэдээлэл буюу материалд дараах зүйлүүдийг оруулна:
- 5.16.1. Хувьцаа эзэмшигч хувьцааг эргүүлэн худалдан авах шаардлагыг эрхийнхээ дагуу тавих үеийн тухайн хувьцааны зах зээлийн үнийн талаар хөндлөнгийн үнэлгээчний дүгнэлт;
  - 5.16.2. Тайлангийн хугацааны банкны хөрөнгийн цэвэр үнэлгээний тооцоо;
  - 5.16.3. Хувьцааг эргүүлэн худалдан авах тухай болон эргүүлэн худалдан авах үнийн талаар шийдвэр гаргасан ТУЗ-ийн хурлын тэмдэглэл /эсвэл холбогдох хэсэг/;
  - 5.16.4. Шаардлагатай бусад мэдээлэл.
- 5.17. ХЭХ-аар банкиг өөрчлөн байгуулах асуудлыг хэлэлцэх бол ХЭХ-д оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигч нь дараах мэдээлэл, материалыг хүлээн авна:
- 5.17.1. Өөрчлөн байгуулах тухай танилцуулга болон өөрчлөн байгуулах нөхцөл;
  - 5.17.2. Өөрчлөн байгуулалтад оролцох бүх банкны ХЭХ-ын өмнөх гурван жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан эсвэл банк гурваас цөөн жил үйл ажиллагаа явуулж байгаа бол үйл ажиллагаа явуулж ирсэн жил бүрийн тайлангууд;
  - 5.17.3. Өөрчлөн байгуулахад оролцож байгаа бүх банкны ХЭХ-ын өмнөх улирлын санхүүгийн тайлан;
  - 5.17.4. Өөрчлөн байгуулснаар үүсэх бүх банкнуудын үүсгэн байгуулах тухай баримт бичгийн төслүүд;
  - 5.17.5. Нэгтгэх /нийлүүлэх/ тухай байгуулсан хэлэлцээрийн хувь болон хуваах эсвэл өөрчлөх тухай гарсан шийдвэрийн хувь.
- 5.18. Банк нь ХЭХ хийх тухай мэдэгдэл гаргасан өдрөөс эхлэн хувьцаа эзэмшигчийг дээрх баримт бичигтэй танилцах боломжоор хангах үүрэгтэй.

### **ЗУРГАА. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛД САНАЛ ОРУУЛАХ**

- 6.1. Саналын эрх бүхий энгийн хувьцааны 5 (тав) буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар болон ТУЗ / ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэхдээ хараат бус гишүүн, ердийн гишүүний аль нь болохыг заах бөгөөд хараат бус гишүүнд нэр дэвшүүлж байгаа тохиолдолд энэ хуулиар тогтоосон шалгуурыг хангаж байгааг нотолсон байх/, тооллогын комиссын гишүүнд нэр дэвшүүлэх этгээдийн талаарх саналаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулахаар өмнөх санхүүгийн жил дууссанаас хойш 60 (жар) хоногийн дотор ТУЗ, эсхүл Гүйцэтгэх удирдлагад гаргаж болно.

- 6.2. Гүйцэтгэх удирдлага энэ журмын 6.1 дэх хэсэгт заасны дагуу гаргасан саналыг ТУЗ-д ажлын 3 (гурав) хоногийн дотор хүргүүлнэ.
- 6.3. Хувьцаа эзэмшигчийн дэвшүүлэх санал нь тухайн саналыг хурлын хэлэлцэх асуудалд шууд тусгахуйцаар найруулан бичигдсэн байна. Мөн гаргах шийдвэрийн төслийг агуулсан байж болно.
- 6.4. ХЭХ-ын хэлэлцэх асуудал болон нэр дэвшүүлэх саналыг бичгээр үйлдэх ба дараах асуудлыг тусгана.Үүнд:
- 6.4.1. Санал дэвшүүлж байгаа хувьцаа эзэмшигчийн нэр;
- 6.4.2. Эзэмшиж байгаа хувьцааны тоо ба төрөл;
- 6.4.3. Дэвшүүлж байгаа саналын тухай болон тухайн саналыг дэвшүүлэх болсон шалтгаан.
- 6.5. Энэ журмын 6.1 дэх хэсэгт заасны дагуу гаргасан санал нь хууль тогтоомжид заасан үндэслэл, мэдээлэл, шаардлагыг хангаж байгаа бол ХЭХ-ын хэлэлцэх асуудлын жагсаалт, нэр дэвшигчдийн бүртгэлд бүртгэх эсэх асуудлыг ТУЗ шийдвэрлэж, Компанийн тухай хуулийн бб дугаар зүйлд заасан журмын дагуу санал гаргасан этгээдэд мэдэгдэнэ.
- 6.6. ТУЗ энэ журмын 6.1 дэх хэсэгт заасны дагуу гаргасан саналыг дор дурдсанаас бусад тохиолдолд ХЭХ-ын хэлэлцэх асуудлын жагсаалтад уг саналыг хүлээн авснаас хойш ажлын 15 өдрийн дотор багтаан оруулах үүрэг хүлээнэ.
- 6.6.1. Санал гаргагч нь энэ журмын 6.1 дэх хэсэгт заасан шаардлагыг хангаагүй;
- 6.6.2. Хувьцаа эзэмшигчийн гаргасан саналд хувьцаа эзэмшигчийн гаргаж байгаа санал, түүний үндэслэл, санал оруулж байгаа хувьцаа эзэмшигчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, түүний эзэмшлийн хувьцааны төрөл, тоог бүрэн тусгаагүй;
- 6.7. Энэ журмын 6.1 дэх хэсэгт заасны дагуу гаргасан хувьцаа эзэмшигчийн саналыг ТУЗ санал гаргагчийн зөвшөөрөлгүйгээр түүний саналыг өөрчлөх эрхгүй.
- 6.8. Энэ журмын 6.1 дэх хэсэгт заасан санал гаргаж, саналыг хүргүүлэхдээ хувьцаа эзэмшигч нь гарын үсгээ зурна. Хэрэв тухайн саналд хувьцаа эзэмшигчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч гарын үсэг зурсан бол хуулийн дагуу хийгдсэн итгэмжлэлийг /эсвэл итгэмжлэлийн баталгаажуулсан хувь/ хавсаргана.
- 6.9. ХЭХ-ын хурлаар хэлэлцэхээр товлоогүй асуудлыг хэлэлцэхгүй.

### **ДОЛОО. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИСС**

- 7.1. ХЭХ хуралдуулах шийдвэр гаргасан этгээд хурлын тооллогын комиссыг томилох бөгөөд уг комиссын үүргийг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэхээр тогтоож болно.

- 7.2. ХЭХ-ын хэлэлцэх асуудалтай шууд холбоотой банкны эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийг хурлын тооллогын комиссын гишүүнээр томилохыг хориглоно.
- 7.3. ХЭХ-ын тооллогын комисс дараах үүрэг хүлээнэ.
  - 7.3.1. Хурлын ирц /кворум/-ыг тогтоож, хурлын даргад мэдээлэх;
  - 7.3.2. Тухайн хурлын хэлэлцэх асуудал тус бүрээр оролцогч бүрийн саналын эрхийн тоо, төрлийг тогтоох;
  - 7.3.3. ХЭХ-д оролцож, санал өгөх эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан гарах асуудалд тайлбар өгөх;
  - 7.3.4. Санал өгөх журмыг тайлбарлах;
  - 7.3.5. Санал өгөх журам болон хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхийг хангах;
  - 7.3.6. Санал хураалтыг цахим хэлбэрээр явуулах нөхцөлийг бүрдүүлсэн санал хураалтын цахим системийг ашиглах, саадгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, хувьцаа эзэмшигчдэд ашиглах зааврыг танилцуулах;
  - 7.3.7. Энэ журмын 9.7 дахь хэсэгт заасны дагуу урьдчилан ирүүлсэн саналын хуудсыг хүлээн авч, санал хураах цахим системд нэгдсэн журмаар бүртгэж, саналыг тоолох;
  - 7.3.8. ХЭХ-ын үеэр цаасан хэлбэрээр өгсөн санал өгсөн саналын хуудсыг тоолж, хүлээн авч, санал хураах цахим системд нэгдсэн журмаар бүртгэж, саналыг тоолох;
  - 7.3.9. Хувьцаа эзэмшигч ХЭХ-ын хэлэлцэх асуудал бүрээр ХЭХ-ын үед цахим хэлбэрээр санал өгөх боломжийг санал хураалтын цахим системийг ашиглан бүрдүүлж, санал хураалтыг зохион байгуулах;
  - 7.3.10. Санал хураалтын дүнгийн талаар тэмдэглэл хөтлөх;
  - 7.3.11. Санал тоолж, санал хураалтын дүнг нэгтгэж, дүнгийн тухай шийдвэр гарган тооллогын комиссын дарга гарын үсэг зурж, хуралд танилцуулах;
  - 7.3.12. Саналын хуудсыг банкны архив болон эрх бүхий байгууллагад хадгалуулахаар шилжүүлэх.
- 7.4. ХЭХ-ын тооллогын комиссын дарга нь тооллогын үр дүнгийн үнэн зөвийг хариуцна.
- 7.5. ТУЗ-өөс ХЭХ-ын тооллогын комисст хурал хуралдуулахтай холбогдсон бусад үүргийг хариуцуулж болно.
- 7.6. Тооллогын комисс нь санал хураалтын хураангуй дүн болон дүнгийн тэмдэглэлийн төслийг ХЭХ-ын санал хураалт дуусмагц санал хураалтын цахим системийг ашиглан бэлэн болгоно. Санал хураалтын дүнгийн тухай тооллогын комиссын тэмдэглэлд тооллогын комиссын дарга болон гишүүд гарын үсэг зурна.
- 7.7. Тооллогын комиссын ХЭХ-ын санал хураалтын дүнгийн тухай илтгэлд дараах мэдээллийг тусгана:
  - 7.7.1. Банкны оноосон бүтэн нэр, хаяг;

- 7.7.2. ХЭХ-ын төрөл болон хуралдуулсан хэлбэр;
- 7.7.3. ХЭХ-ын хуралдсан өдөр, байршил, бөглөсөн саналын хуудсыг буцаан хүргүүлсэн шуудангийн хаяг, хэрэв ХЭХ-ыг эчнээ хэлбэрээр хуралдуулсан бол саналын хуудсыг эргүүлэн хүлээн авах сүүлийн хугацаа, бөглөсөн саналын хуудсыг эргүүлэн хүргүүлсэн шуудангийн хаяг;
- 7.7.4. ХЭХ-ын хэлэлцсэн асуудал;
- 7.7.5. ХЭХ-аар шийдвэрлэсэн асуудлууд, тухайн асуудлуудаар товлосон хугацаанд саналын хуудсаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт болон тэдгээр хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж байгаа хувьцааны тоо;
- 7.7.6. Хэлэлцсэн асуудал бүрээр хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн хувьцаа эзэмшигчдээс ирүүлээгүй саналын тоо;
- 7.7.7. Хэлэлцсэн асуудал бүрээр ХЭХ-д оролцсон хувьцаа эзэмшигчдийн саналын тоо болон тухайн хэлэлцсэн асуудлаар ирц бүрдсэн эсэх тухай мэдээлэл;
- 7.7.8. Ирц бүрдсэн нөхцөлд хэлэлцсэн асуудал бүрээр өгсөн саналын тоо /"зөвшөөрсөн", "татгалзсан", түдгэлзсэн"/;
- 7.7.9. ХЭХ-аар хэлэлцсэн асуудал бүрээр өгсөн саналын хүчингүй болсон саналын хуудасны тоо;
- 7.7.10. Хурлаар хэлэлцсэн асуудал бүрээр гаргасан шийдвэрийн томъёолол;
- 7.7.11. Тооллогын комиссын үүргийг гүйцэтгэсэн хөндлөнгийн байгууллагын нэр, хаяг, тухайн байгууллагаас ХЭХ-ын Тооллогын комиссын ажлыг эрхлэн гүйцэтгэх эрх олгосон хүмүүсийн нэрс;
- 7.7.12. ХЭХ-ын дарга, нарийн бичгийн даргын нэр;
- 7.7.13. Тооллогын комиссын дарга болон гишүүдийн гарын үсэг;
- 7.7.14. Санал хураалтын дүнгийн тайланг бичсэн огноо.

### **НАЙМ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ИРЦ, ХУРАЛ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ**

- 8.1. Банкны саналын эрх бүхий хувьцааны 50 (тавь)-иас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид ХЭХ-д оролцоноор тухайн хурал хүчин төгөлдөр болно.
- 8.2. Энэ журмын 8.1 дэх хэсэгт заасан хувь хүрээгүй бол ХЭХ-ыг хүчин төгөлдөр бус гэж үзэн тухайн хурлыг хойшлуулж, дахин хуралдах өдрийг ТУЗ товлох бөгөөд Компанийн тухайн хуульд заасан нөхцөл, журмын дагуу ХЭХ-ын зарыг дахин мэдээлнэ.
- 8.3. Энэ журмын 8.2 дахь хэсэгт заасны дагуу хойшлогдсон ХЭХ-ыг ажлын 20 (хорь) өдрийн дотор хуралдуулах бөгөөд уг хурал хуралдахаас ажлын 7 (долоо)-оос доошгүй өдрийн өмнө ХЭХ болох газар, өдөр, цагийг дахин мэдээлнэ.
- 8.4. Энэ журмын 8.2 дахь хэсэгт заасны дагуу хойшлогдсон ХЭХ-д бүртгэлийн өдрийг өөрчлөхгүй.

- 8.5. Энэ журмын 8.2 дахь хэсэгт заасны дагуу хүчин төгөлдөр бус гэж үзсэн хувьцаа эзэмшигчдийн хуралд ирүүлсэн саналыг хойшлогдсон хурлын ирц, санал хураалтын дүнд оруулан тооцно.
- 8.6. Хойшлогдсон ХЭХ нь энэ журмын 8.5 дахь хэсэгт заасан хугацаанд хуралдаж чадаагүй бол шинээр хурал зарлах бөгөөд ирц /кворум/-ийг журмын 8.1 дэх хэсэгт зааснаар тогтооно.

## **ЕС. САНАЛЫН ХУУДАС**

- 9.1. Банкны ХЭХ-аар шийдвэрлэх асуудлаар өгөх саналыг саналын хуудсаар авна.
- 9.2. Хувьцаа эзэмшигч энэ журмын 9.1 дэх хэсэгт заасны дагуу өгөх саналаа саналын хуудсанд тэмдэглэн тогтоосон журмын дагуу ХЭХ-ын тооллогын комисст ирүүлнэ.
- 9.3. Энэ журмын 9.1 дэх хэсэгт заасан саналын хуудасны агуулга, загварыг ХЭХ-ыг зарласан этгээд батална.
- 9.4. Саналын хуудсанд дараах зүйлийг тусгана.
  - 9.4.1. Банкны оноосон нэр;
  - 9.4.2. ХЭХ хурлын хэлбэр;
  - 9.4.3. Хурал хуралдах газар, өдөр, цаг болон урьдчилан бөглөсөн саналын хуудсыг эргүүлэн хүргүүлэх шуудангийн хаяг;
  - 9.4.4. Хувьцаа эзэмшигчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, түүний эзэмшлийн хувьцааны төрөл, тоо;
  - 9.4.5. Санал хураалтаар шийдвэрлэх асуудлын томъёолол, асуудал бүрээр “зөвшөөрсөн”, “татгалзсан”, “түдгэлзсэн” санал өгөх тэмдэглэгээ, эсхүл өөр тусгайлсан санал гаргах зай;
  - 9.4.6. ТУЗ-ийн гишүүдийг сонгоход ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, санал хураах кумулятив аргын тайлбар, санал өгөх тэмдэглэгээ;
  - 9.4.7. Саналын хуудсанд хувьцаа эзэмшигчийн гарын үсэг, огноог тэмдэглэх зай, эсхүл цахим хэлбэрээр нөхөгдөн бичигдэх боломж.
- 9.5. Хувьцаа эзэмшигч ердийн журмаар саналаа өгөхдөө асуудал бүрээр “зөвшөөрсөн”, “татгалзсан”, “түдгэлзсэн” аль нь болохыг тэмдэглэсэн саналын хуудсыг, кумулятив аргаар санал өгөхөд уг аргын тухай тайлбар бүхий тухайн нэр дэвшигчид өгөх саналын тоог тус тус тэмдэглэсэн саналын хуудсыг хэрэглэнэ.
- 9.6. Хэрэв саналыг хувьцаа эзэмшигчийн төлөөлөгч өгч байгаа бол бөглөсөн саналын хуудсыг хувьцаа эзэмшигчийг төлөөлөх эрхийн итгэмжлэлийн хамт хүчинтэй байна.
- 9.7. Саналын хуудсаар санал урьдчилан авах тохиолдолд санал авах саналын хуудсыг

хүлээн авах газар, сүүлчийн хугацааг хурлын зард тусгайлан мэдээлнэ.

### **АРАВ. САНАЛЫН ХУУДСЫГ ХҮЧИНТЭЙД ТООЦОХ**

10.1. ХЭХ-аар хэлэлцэх асуудалд өгсөн саналыг дараах тохиолдолд хүчинтэйд тооцно.

10.1.1. ТУЗ-ийн гишүүнийг сонгохоос бусад тохиолдолд буюу ердийн журмаар санал өгөх асуудалд санал өгөх хувилбарын зөвхөн 1 (нэг)-ийг тэмдэглэсэн;

10.1.2. ТУЗ-ийн гишүүдийг сонгох тохиолдолд ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч бүрд өгсөн саналын тооны нийлбэр нь тухайн хувьцаа эзэмшигчийн саналын эрхийн тооны нийт дүнгээс илүүгүй байх бөгөөд саналын эрхийн тооны нийт дүн нь тухайн хувьцаа эзэмшигчийн эзэмшиж байгаа саналын эрх бүхий энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна.

10.2. Саналын хуудсаар 1 (нэг)-ээс дээш санал хураах асуудал тусгагдсан тохиолдолд тухайн саналд холбогдох хэсэгт энэ журмын 10.1 дэх хэсэгт заасны дагуу хийсэн тэмдэглэгээг хүчинтэйд тооцох бөгөөд тухайн саналд буруу тэмдэглэл хийгдсэн саналын хуудас нь бүхэлдээ хүчингүйд тооцогдохгүй.

### **АРВАННЭГ. ЭЧНЭЭ САНАЛ ХУРААЛТААР БАНКНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД ШИЙДВЭР ГАРГАХ**

11.1. ХЭХ-ын бүрэн эрхэд хамаарах асуудлыг хурал хуралдуулахгүйгээр хувьцаа эзэмшигчдээс эчнээ санал хураалт явуулах замаар шийдвэрлэж болох бөгөөд эчнээ санал хураалтыг саналын хуудсыг ашиглан явуулна.

11.2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал болон дахин товлогдсон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг эчнээ санал хураалтаар орлуулахыг хориглоно.

11.3. Эчнээ санал хураалт явуулах шийдвэрийг ТУЗ гаргах бөгөөд уг шийдвэрт дараах зүйлийг тусгана.

11.3.1. Эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудал;

11.3.2. Саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдөр;

11.3.3. Саналын хуудсыг хувьцаа эзэмшигчид хүргүүлэх хугацаа;

11.3.4. Саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдөр;

11.3.5. Саналын хуудасны агуулга болон загвар;

11.3.6. Эчнээ санал хураалт явуулахтай холбогдуулан хувьцаа эзэмшигчид танилцуулах баримт бичгийн жагсаалт, тэдгээртэй танилцах газар.

11.4. Эчнээ санал хураалтад оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг энэ журмын 5 дугаар зүйлд заасны дагуу тодорхойлно.

11.5. Эчнээ санал хураалтын саналын хуудсанд банкны нэр, хувьцаа эзэмшигчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, түүний эзэмшлийн хувьцааны төрөл, тоо, санал хураалтаар шийдвэрлэх асуудлын томъёолол, ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийн эцэг /эх/-ийн

нэр, өөрийн нэр, ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгоход хэрэглэх санал хураах кумулятив аргын тайлбар зэргийг мэдээллийг тусгахын зэрэгцээ саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдрийг заасан байна.

- 11.6. Эчнээ санал хураалтын саналын хуудсыг эргүүлэн хүлээн авах сүүлчийн өдрөөс ажлын 30 (гуч)-аас доошгүй өдрийн өмнө хувьцаа эзэмшигчид тараана.
- 11.7. Нийт саналын эрхийн 50 (тавь)-иас дээш хувийг эзэмшигчид саналаа ирүүлснээр эчнээ санал хураалтыг хүчинтэйд тооцно.
- 11.8. Эчнээ санал хураалтаар ирүүлсэн саналыг тоолох, дүнг гаргах ажлыг энэ журмын 7 дугаар зүйлд заасан эрх, үүрэг бүхий тооллогын комисс зохион байгуулна.
- 11.9. Хурлын тооллогын комисс нь саналын хуудсыг хүлээн авсан сүүлчийн өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор эчнээ санал хураалтын дүнгийн тухай тайлан гаргаж, тооллогын комиссын дарга, гишүүд гарын үсэг зурж, ТУЗ-д хүлээлгэн өгнө.
- 11.10. Эчнээ санал хураалтын дүнгийн тухай тайланд дараах зүйлийг тусгана.
  - 11.10.1. Саналын хуудсыг хувьцаа эзэмшигчдэд тараасан өдөр;
  - 11.10.2. Эчнээ санал хураалтаар шийдвэрлэсэн асуудал;
  - 11.10.3. Санал ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт, эзэмшиж байгаа хувьцааны тоо;
  - 11.10.4. Шийдвэрлэх асуудал бүрээр саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн өгсөн саналын нийт тоо;
  - 11.10.5. Эчнээ санал хураалтын дүн;
  - 11.10.6. Эчнээ санал хураалтаар гаргасан шийдвэр.
- 11.11. Хурлын тооллогын комиссын тайланг үндэслэн ТУЗ шийдвэр гаргах бөгөөд уг шийдвэрийг тайлан хүлээн авснаас хойш ажлын 7 (долоо) өдрийн дотор хувьцаа эзэмшигчид мэдээлнэ.

### **АРВАНХОЁР. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

- 12.1. ХЭХ дууссанаас хойш ажлын 15 (арван тав) өдрийн дотор хурлын тэмдэглэлийг гаргаж, хурлын дарга гарын үсэг зурах бөгөөд уг тэмдэглэлийн үнэн зөвийг хурлын дарга хариуцна.
- 12.2. ХЭХ-ын тэмдэглэлд дараах мэдээллийг агуулсан байна.
  - 12.2.1. Банкны албан ёсны нэр, хаяг, хурал болсон газар, он, сар, өдөр, цаг;
  - 12.2.2. Хурлын даргын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;
  - 12.2.3. Хурлаар хэлэлцсэн асуудал;
  - 12.2.4. Хувьцаа эзэмшигчдийн саналын эрхийн тоо, хурлын ирц;
  - 12.2.5. Саналын хуудас хэрэглэсэн бол уг саналын хуудасны загвар;
  - 12.2.6. Хурлаар шийдвэрлэсэн асуудал тус бүрээр зөвшөөрсөн, татгалзсан, түдгэлзсэн саналын тоо, гаргасан шийдвэрийн бүрэн томъёолол;
  - 12.2.7. Саналын хуудсыг бөглөж, банканд эргүүлэн ирүүлэх шуудангийн хаяг хэрэв тийнхүү ирүүлж болохоор заасан байвал;



- 12.2.8. Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтад орсон хувьцаа эзэмшигчдийн саналын тоо нь хэлэлцэх асуудал бүрд хамаарна;
- 12.2.9. ХЭХ-ын тэмдэглэл /протокол/ үйлдсэн огноо;
- 12.2.10. ХЭХ-ын шийдвэр.
- 12.3. ХЭХ-ын тэмдэглэлд алдаа гарсан нь уг хурлын шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болохгүй.
- 12.4. ХЭХ-ын тэмдэглэлд бичсэн ХЭХ-ын асуудал бүрээр гаргасан шийдвэрийн томъёолол нь саналын хуудсанд бичигдсэн тухайн шийдвэрийн томъёоллоос өөр байж үл болно.
- 12.5. ХЭХ-ын хэлэлцэх асуудалд нэгдмэл сонирхолтой талуудын хэлцэлтэй холбогдсон асуудал орсон бол ХЭХ-ын тэмдэглэл, тооллогын комиссын тэмдэглэл, санал хураалтын дүнгийн тухай тайланд тухайн асуудлаар дараах мэдээллийг оруулна.
- 12.5.1. Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтад орсон, тухайн хэлцлийн хувьд нэгдмэл сонирхолгүй хувьцаа эзэмшигчдийн саналын тоо;
- 12.5.2. ХЭХ-д биечлэн оролцсон, тухайн хэлцлийн хувьд нэгдмэл сонирхолгүй хувьцаа эзэмшигчдийн саналын тоо;
- 12.5.3. Ангилал бүрээр өгсөн саналын тоо /"зөвшөөрсөн", "татгалзсан", "түдгэлзсэн"/
- 12.6. ХЭХ-ын хэлэлцэх асуудалд давуу эрхийн аль нэг төрлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хязгаарлах нэмэлт өөрчлөлтийг банкны дүрэмд оруулах /шинэчлэн найруулсан дүрмийг батлах/ эсвэл банкны дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлт нь хуулийн дагуу давуу эрхийн аль нэг төрлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хязгаарлах асуудал орсон бол ХЭХ-ын тэмдэглэл, тооллогын комиссын тэмдэглэлд тухайн асуудлаар дараах мэдээллийг оруулна.
- 12.6.1. Эрх нь хязгаарлагдаж болох давуу эрхийн хувьцаа эзэмшигчдийн саналын тоог оролцуулахгүйгээр хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн хувьцаа эзэмшигчдийн саналын тоо;
- 12.6.2. Эрх нь хязгаарлагдаж болох давуу эрхийн хувьцаа эзэмшигчдийн саналын тоо;
- 12.6.3. ХЭХ-д биечлэн оролцсон хувьцаа эзэмшигчдийн саналын тоо /үүнд эрх нь хязгаарлагдаж болох давуу эрхийн хувьцаа эзэмшигчдийн саналын тоо орохгүй бөгөөд тэдгээр давуу эрхийн хувьцаа эзэмшигчдийн саналын тоог жичид нь гаргана/;
- 12.6.4. Хэлэлцсэн асуудлаар өгсөн саналын ангилал бүрийн тоо /"зөвшөөрсөн", "татгалзсан", "түдгэлзсэн"/, үүнд эрх нь хязгаарлагдаж болох давуу эрхийн хувьцаа эзэмшигчдийн саналын тоо орохгүй бөгөөд тэдгээр давуу эрхийн хувьцаа эзэмшигчдийн өгсөн саналын ангилал бүрийн /"зөвшөөрсөн", "татгалзсан", "түдгэлзсэн"/ тоог жичид нь гаргах;
- 12.7. Банк болон хувьцаа эзэмшигч нь шаардлагатай гэж үзвэл ХЭХ-ын тэмдэглэлийн үнэн зөвийн баталгаа болгож тодорхой техник хэрэгсэл ашиглан бичлэг хийж болно.
- 12.8. Хувьцаа эзэмшигч бичлэг хийсэн тохиолдолд түүний хувийг банк шаардан авч хадгална.
- 12.9. ХЭХ-аас гаргасан шийдвэр болон санал хураалтын дүнг ХЭХ дээр зарлан мэдэгдэх эсвэл хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтад орсон хувьцаа эзэмшигчдэд санал хураалтын дүнгийн илтгэлийг ТУЗ хүлээн авснаас хойш ажлын долоо хоногт багатаан

хувьцаа эзэмшигчдийн бүртгэлд байгаа хаягаар баталгаат шуудангаар хүргүүлнэ.

12.10. ХЭХ-ын тэмдэглэлд гарын үсэг зурагдсаны дараа, тооллогын комисс саналын хуудаснуудыг лацдаж, банкны архивд хадгална.

### **АРВАНГУРАВ. ГОМДОЛ ГАРГАХ**

13.1. ХЭХ, түүний шийдвэрийн талаар хуралд оролцоогүй, эсхүл оролцсон боловч эсрэг саналтай байсан хувьцаа эзэмшигч дараах үндэслэлээр шүүхэд гомдол гаргаж болно.

13.1.1. Банкны тухай хууль, түүнд нийцүүлэн эрх бүхий байгууллагаас тогтоосон журам, энэ журам болон банкны дүрэмд заасны дагуу ХЭХ-ыг зарлаагүй;

13.1.2. ХЭХ хуралдах шийдвэр гарснаас хойш хуралдах өдөр, газрыг өөрчилсөн;

13.1.3. ХЭХ-аар хэлэлцэхээр товлоогүй асуудлыг хэлэлцсэн.

13.2. Хуралд оролцоогүй, эсхүл оролцсон боловч эсрэг саналтай байсан хувьцаа эзэмшигч энэ журмын 13.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр Санхүүгийн зохицуулах хороонд гомдол гаргах эрхтэй.

### **АРВАНДӨРӨВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

14.1. ХЭХ-ыг банкны байранд эсвэл дийлэнх хувьцаа эзэмшигчдийн хувьд очиход төвөггүй өөр газар хуралдахаар зохион байгуулна.

14.2. ХЭХ нэг өдөрт буюу тухайн ХЭХ хуралдаж буй өдрийн 22:00 цагт багтаж хэлэлцэх асуудлыг дуусгахгүй тохиолдолд ХЭХ-ын дарга дараа өдрийн өглөө хүртэл буюу 06:00 цагаас хойш үргэлжлүүлэн хуралдахаар хурлыг завсарлуулна.

14.3. ХЭХ-ыг тухайн өдрийн 22:00-06:00 цагийн хооронд хуралдуулахыг хориглоно.

14.4. ХЭХ-д оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн ирцийн бүртгэлийг ХЭХ эхлэхээс өмнө 1 (нэг)-ээс доошгүй цагийн өмнө ХЭХ-ын зард заасан хуралдах байранд эхлүүлнэ

14.5. ХЭХ-д оролцогсдын ирцийн бүртгэлийг цахим техник хэрэгсэл ашиглан ХЭХ хуралдах байранд хийнэ.

14.6. ХЭХ-ын дарга нь ХЭХ-ыг удирдан явуулах бөгөөд ХЭХ-ын тэмдэглэл, шийдвэрт гарын үсэг зурж баталгаажуулна.

14.7. ХЭХ-ын эхэнд Тооллогын комиссын дарга ХЭХ-ын ирцийг мэдээлж, ХЭХ-аар хэлэлцэх асуудал бүрээр хэрхэн санал өгөх талаар дэлгэрэнгүй тайлбарлана.

14.8. ХЭХ-ын дарга ХЭХ-д оролцож байгаа этгээдийг танилцуулж, хэлэлцүүлэх асуудлаар илтгэл тавих, холбогдох асуулт асуух, хариулт өгөх дарааллыг тайлбарлана.

14.9. Санал хураах асуудал бүрээр үг хэлэх, асуулт, санал хэлэх, хариулт өгөх хугацаа тус бүрд 2 (хоёр) минут байна.

14.10. ХЭХ-ын дарга нь хэлэлцэх асуудлаар явагдах хэлэлцүүлгийн үр дүнтэй байх нөхцөлийг хангаж, санал хураахгүй асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлэхгүй байна.

14.11. ХЭХ-аар хэлэлцэх асуудлыг бүрэн хэлэлцэж дууссаны дараа, ХЭХ-ын дарга гарах шийдвэрийг танилцуулж, санал хураалтыг эхлүүлнэ.

14.12. ХЭХ-аар хэлэлцсэн асуудалд санал өгөхдөө “нэг хувьцаа-нэг санал” гэсэн зарчмыг

баримтлах ба харин кумулятив аргаар санал хураахад энэ зарчим хамаарахгүй.

- 14.13. Санал хураалтыг цахим хэлбэрээр явуулах бөгөөд энэ журмын 9.7 дахь хэсэгт ирүүлсэн саналыг тооллогын комисс цахим системд урьдчилан бүртгэж, саналыг тоолсон байна.
- 14.14. Хувьцаа эзэмшигч ХЭХ-ын үеэр хүндэтгэн үзэх шалтгааны улмаас цаасан хэлбэрээр санал өгч болох бөгөөд тооллогын комисс цаасан хэлбэрээр өгсөн саналын хуудсыг санал хураалтын цахим системд бүртгэж, дүнг нэгтгэнэ.
- 14.15. ХЭХ хурлын санал хураалтын дүнг тооллогын комиссын дарга уншиж танилцуулсны дараа ХЭХ-ын дарга ХЭХ-аас гарах шийдвэрийг уншиж танилцуулснаар ХЭХ-ын үйл ажиллагааг дуусгавар болно.
- 14.16. ХЭХ-ын материалыг ХЭХ хурал хуралдсанаас хойш ажлын 3 (гурав) хоногт багтаан ТУЗ-ийн дэргэдэх Засаглалын албанаас зохих журмын дагуу бэлтгэн Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлнэ.

### **АРВАНТАВ. ХАРИУЦЛАГА, ИЛ ТОД БАЙДАЛ**

- 15.1. ХЭХ хуралдсанаас хойш ажлын 3 (гурав) хоногийн дотор ХЭХ-ын хурлын шийдвэрийн талаар олон нийтэд ил тод, нээлттэй хэлбэрээр хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон цахим хэлбэрээр мэдээлнэ.
- 15.2. Энэ журамд заасныг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

## **“ТӨРИЙН БАНК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ**

### **“Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын журам батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалт, “Төрийн банк” ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5.17 дахь заалт, “Төрийн банк” ХК-ийн 2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Төрийн банк” ХК-ийн “Хувьцаа эзэмшигчдийн хурлын журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан “Төрийн банк” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 01/1 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

2. “Төрийн банк” ХК-ийн “Хувьцаа эзэмшигчдийн хурлын журам”-ын хэрэгжилтийг ханган ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /Б.Тэлмүүн/, Гүйцэтгэх захирал /Ө.Гантөр/-д тус тус даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

С.МӨНГӨНЧИМЭГ

“Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 2023 оны ... дугаар сарын ...-ны өдрийн ...дугаар тогтоолын хавсралт

## “ТӨРИЙН БАНК” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэ журмын зорилго нь “Төрийн банк” ХК /цаашид “банк” гэх/-ийн Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/-ийн бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, ТУЗ-ийн дарга, гишүүний үүрэг, ТУЗ-ийн хурлын үйл ажиллагаа, баримтлах ёс зүйн хэм хэмжээг тогтоохтой холбогдох харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. ТУЗ нь Банкны тухай хууль, Компанийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон эрх бүхий байгууллагаас батлан гаргасан хүчин төгөлдөр бүхий эрх зүйн баримт бичиг, банкны дүрэмд нийцүүлэн үйл ажиллагаагаа хэрэгжүүлнэ.

### ХОЁР. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 2.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт банкны эрх барих байгууллага нь ТУЗ байна.
- 2.2. ТУЗ-ийг хууль тогтоомж болон банкны дүрэмд заасны дагуу байгуулах бөгөөд банкны дүрэмд заасан ердийн болон хараат бус гишүүдээс бүрдэнэ.
- 2.3. ТУЗ-ийн дэргэд байнгын ажиллагаатай Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороо, Аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хороотой байна.
- 2.4. ТУЗ нь банкны дүрэмд заасны дагуу ТУЗ-ийн нарийн бичгийн дарга болон Засаглалын албатай байна.
- 2.5. ТУЗ-ийн гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга болон Засаглалын албаны ажилтнууд компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна.
- 2.6. ТУЗ-ийн үйл ажиллагааны үндсэн зохион байгуулалтын хэлбэр нь хурал байх бөгөөд хурал нь ээлжит болон ээлжит бус байж болно.
- 2.7. ТУЗ нь өөрийн тогтоолын хэвлэмэл хуудас, тэмдэгтэй байна.

### ГУРАВ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЧИГ ҮҮРЭГ

- 3.1. ТУЗ нь хууль тогтоомжоор олгогдсон эрх, үүргийг хэрэгжүүлэхээс гадна банкны дүрмийн 10 дугаар зүйлд заасан эрхийг хэрэгжүүлнэ.
- 3.2. ТУЗ нь шаардлагатай гэж үзсэн дараах асуудлаар банкны эрх бүхий албан тушаалтнаас тайлбар гаргуулан авч хэлэлцэх эрхийг хэрэгжүүлж болно. Үүнд:
  - 3.2.1. Хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын шийдвэр болон бодлогод заасан зохистой харьцаа, хязгаарлалтыг зөрчиж хийсэн ажил гүйлгээ;

- 3.2.2. Банкны хувьцаа эзэмшигч, банкны эрх бүхий албан тушаалтан, тэдгээрийн холбогдох этгээдтэй байгуулсан гэрээ хэлцэл, түүнтэй холбоотойгоор үүссэн эрсдэл;
  - 3.2.3. Банкны санхүү, төлбөрийн чадвар, тогтвортой байдал болон бусад үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэх ажил, гүйлгээ, гэрээ хэлцэл.
  - 3.2.4. Банкны удирдлага, зохион байгуулалт, түүнийг боловсронгуй болгох асуудал;
  - 3.2.5. Банкны үйл ажиллагаатай холбогдуулан ТУЗ-ийн дэргэдэх хороодын гаргасан санал, дүгнэлт, зөвлөмжид холбогдох асуудал;
  - 3.2.6. Банкны эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаа, ёс зүйн зөрчлийн талаар гаргасан ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны дүгнэлтийг хэлэлцэх, шаардлагатай нөхцөлд гүйцэтгэх захирал, банкны эрх бүхий албан тушаалтныг ажилтныг ажлаас түдгэлзүүлэх санал.
- 3.3. ТУЗ банкны менежмент, үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр тодорхой үүрэгтэй ажлын хэсгийг хараат бусаар байгуулж, ажил үүргийн хуваарийг тогтоон ажиллуулж болно.
  - 3.4. Энэ журмаар зохицуулагдаагүй бусад асуудлыг хууль тогтоомж болон банкны дүрэмд нийцүүлэн ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

### **ДӨРӨВ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА**

- 4.1. ТУЗ-ийн дарга нь хууль тогтоомж болон банкны дүрмээр тогтоогдсон эрх хэмжээний хүрээнд Гүйцэтгэх удирдлагатай харилцах, банкны нэрийн өмнөөс гэрээ байгуулах, банкны эрх ашгийг төлөөлөх зэргээр банкны нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаагаа явуулна.
- 4.2. ТУЗ-ийн дарга дараах, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
  - 4.2.1. ТУЗ-ийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;
  - 4.2.2. ТУЗ-ийн гишүүдийг чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөл, бололцоогоор хангаж, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын хооронд харилцан хүндэтгэл, итгэлцэл дээр тулгуурласан ажил хэрэгч харилцааг үүсгэн, бэхжүүлэх;
  - 4.2.3. ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудлыг тогтоож хууль тогтоомжийн дагуу зарлан хуралдуулах, хурлыг даргалах, хурлын тэмдэглэл хөтлүүлэх;
  - 4.2.4. ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлж, шийдвэр гаргахад шаардлагатай хэмжээний хангалттай мэдээлэлд үндэслэн хэлэлцэх асуудал тус бүрээр санал хураалт явуулж, шийдвэрийг баталгаажуулах;
  - 4.2.5. ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэх асуудалд ТУЗ-ийн дэргэдэх хороодын санал, дүгнэлт, зөвлөмжийг тусгах зорилгоор хороодын хурлыг хуралдуулах чиглэл өгөх;
  - 4.2.6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зохион байгуулах болон бэлтгэл ажлыг хангахтай холбогдох үүрэг даалгаврыг банкны эрх бүхий албан тушаалтнуудад өгөх;
  - 4.2.7. Шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн хурлыг эчнээ хэлбэрээр зохион байгуулах чиглэл өгөх, эчнээ санал хураалтын ажиллагааг зохион байгуулах;
  - 4.2.8. ТУЗ-ийг төлөөлөн банкны Гүйцэтгэх захиралтай хөдөлмөрийн гэрээ байгуулах;
  - 4.2.9. ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар тайлбар гаргах, ТУЗ-ийн байр суурийг илэрхийлэх;

- 4.2.10. ТУЗ-ийн гишүүд болон ТУЗ-ийн дэргэдэх Засаглалын алба, Дотоод аудитын газар, Комплайнсийн хяналтын чиг үүрэг хариуцсан нэгжийн ажилтнуудыг батлагдсан төсөвт багтаан банкны үйл ажиллагаатай холбогдсон асуудлаар гадаад, дотоодын үзэсгэлэн худалдаа, хурал, семинарт оролцуулах, сургалтад хамруулах, мэдлэг чадварыг дээшлүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авч ажиллах;
- 4.2.11. Шаардлагатай гэж үзвэл банкны бизнес төлөвлөгөө батлах, төсөл хэрэгжүүлэх, зээл авах, үндсэн хөрөнгө худалдаж авах, данснаас хасах, хөрөнгө оруулалт хийх зэрэг ихээхэн хэмжээний хөрөнгө зарцуулахтай холбогдсон асуудлыг ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэхдээ ажлын хэсэг байгуулан судлуулах;
- 4.2.12. ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үйл ажиллагааг хянах, үнэлэх;
- 4.2.13. ТУЗ-ийн шийдвэрийг тайлбарлах, ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар ТУЗ-ийн байр суурийг илэрхийлэх, мэдээлэх;
- 4.2.14. Хууль тогтоомж, дүрэмд заасан бусад.
- 4.3. ТУЗ-ийн даргын түр эзгүйд түүний үүргийг ТУЗ-ийн даргын, эсхүл ТУЗ-ийн томилсон гишүүн гүйцэтгэнэ.
- 4.4. ТУЗ-ийн даргын бүрэн эрх дараах тохиолдолд дуусгавар болно. Үүнд:
  - 4.4.1. Өөрөө хүсэлт гаргасныг ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн;
  - 4.4.2. Гурваас дээш сараар бүрэн эрхээ хэрэгжүүлэх чадваргүй болсон;
  - 4.4.3. Нас барсан;
  - 4.4.4. Хууль тогтоомжид заасан бусад;
- 4.5. ТУЗ-ийн даргын бүрэн эрх дуусгавар болсноос хойш 14 (арван дөрөв) хоногийн дотор ТУЗ-ийн даргыг сонгоно.

### **ТАВ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН**

- 5.1. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүн нь Банкны тухай хууль, Компанийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон эрх бүхий байгууллагаас батлан гаргасан хүчин төгөлдөр бүхий эрх зүйн баримт бичиг, банкны дүрэмд зааснаас гадна дараах эрх, үүргийг хэрэгжүүлж ажиллана. Үүнд:
  - 5.1.1. Хууль тогтоомж болон дүрмээр олгогдсон бүрэн эрхийн хүрээнд үүргээ хариуцлагатай биелүүлж, ТУЗ-ийн болон өөрийн харьяалагдах ТУЗ-ийн дэргэдэх хороодын хуралд товлосон хугацаанд оролцох;
  - 5.1.2. Банк, банкны харилцагчийн эрх ашгийг хамгаалан ёс зүйн зөрчил гаргахгүй байх;
  - 5.1.3. Ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийж, ашиг сонирхлын зөрчил гаргахгүй байх;
  - 5.1.4. Банкны өдөр тутмын үйл ажиллагаанд зүй бусаар оролцохгүй байх;
  - 5.1.5. Хүндэтгэн үзэх шалтгаанаар ТУЗ болон өөрийн харьяалагдах ТУЗ-ийн дэргэдэх хороодын хуралд оролцох боломжгүй тохиолдолд энэ тухайгаа ТУЗ-ийн дарга болон ТУЗ-ийн нарийн бичгийн даргад тухай бүр мэдэгдэх;
  - 5.1.6. ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхэд шаардагдах баримт бичиг, мэдээлэлтэй бүрэн гүйцэд танилцаж, холбогдох саналаа хууль тогтоомжийн хүрээнд гаргах;

- 5.1.7. ТУЗ-ийн гишүүний үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах өөрийн ур чадварыг хөгжүүлэх, мэдлэгээ дээшлүүлэх, банкны үйл ажиллагаа, зохистой засаглалын талаарх сайн туршлага, тэргүүлэх чиг хандлагыг банкны үйл ажиллагаанд нэвтрүүлэх санал гаргаж хэлэлцүүлэх.
  - 5.1.8. ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарах асуудлыг шийдвэрлэхэд шаардагдах холбогдох баримт бичигтэй ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар дамжуулан танилцах;
  - 5.1.9. ТУЗ-ийн шийдвэрийн биелэлтийн талаар компанийн холбогдох албан тушаалтнаас ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар дамжуулан мэдээлэл шаардаж авах;
  - 5.1.10. Албан үүргээ хэрэгжүүлэхдээ олж авсан компанийн дотоод мэдээлэл болон бизнесийн нууцад хамаарах аливаа мэдээллийг ажиллах хугацаандаа болон ажлаас чөлөөлөгдсөний дараа 3 жилийн турш задруулахгүй байх, хувийн ашиг сонирхол болон гуравдагч талын ашиг сонирхлын төлөө ашиглахгүй байх;
  - 5.1.11. ТУЗ-ийн хурлын дэгийг сахиж ажиллах;
  - 5.1.12. Шийдвэр гаргахдаа банкны үйл ажиллагааны үр дүнг сайжруулах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах байр сууринаас ул суурьтай, мэргэжлийн, үнэнч шударга хандах;
  - 5.1.13. ТУЗ-д аливаа сонирхлын зөрчлийн талаар мэдээллээ мэдэгдэж, тухайн асуудлыг шийдвэрлэхэд санал хураалтад оролцохгүй байх.
- 5.2. ТУЗ-ийн хараат бус гишүүн энэ журмын 5.1 дэх хэсэгт зааснаас гадна дараах нэмэлт үүргийг хүлээнэ. Үүнд:
- 5.2.1. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо, Цалин урамшууллын хороо, Нэр дэвшүүлэх хороодыг тэргүүлэн, идэвх санаачилгатай ажиллах;
  - 5.2.2. Банкны үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах талаар банкны эрх бүхий албан тушаалтнаас шаардах, хэрэгжилтийг хянах;
  - 5.2.3. Шаардлагатай тохиолдолд банкны үйл ажиллагаа, бодлого, хариуцлагын асуудлаар хараат бус зөвлөмж, дүгнэлт гаргаж, холбогдох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх;
  - 5.2.4. ХЭХ-д биечлэн оролцож, ТУЗ-ийн шийдвэрийн талаар зарчмын зөрүүтэй байр суурьтай байсан бол энэ тухайгаа мэдээлж, хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулах, тодруулга хийх;
  - 5.2.5. Банкны эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаа, гаргасан шийдвэр нь хувьцаа эзэмшигч болон банкны эрх ашигт сөргөөр нөлөөлсөн эсэх, тэдгээрийн үйл ажиллагаа хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавьж, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шаардлагатай тохиолдолд зөвлөмж, дүгнэлт гаргаж, холбогдох албан тушаалтанд хүргүүлэх;
  - 5.2.6. Зөрчил илэрвэл уг зөрчлийг арилгахыг холбогдох этгээдээс шаардах, шаардлагыг эс биелүүлбэл уг асуудлыг ТУЗ-д тавьж шийдвэрлүүлэх;
  - 5.2.7. Банкны санхүү болон санхүүгийн бус мэдээллийн бүрэн бүтэн байдал, санхүүгийн хяналт, эрсдэлийн менежментийн системийн талаар болон эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хязгаарыг тогтоохдоо хөндлөнгийн мэргэжлийн этгээд /банкны эрх бүхий албан тушаалтан болон зөвлөх үйлчилгээний үр дүн ашиг сонирхолд нь тодорхой хэмжээгээр нөлөөлж болзошгүй аливаа этгээдээс хараат бус байх этгээд/-ийн зөвлөгөөг банкны зардлаар эсхүл үнэ төлбөргүй авах;



- 5.2.8. ТУЗ-ийн хараат бус гишүүний хараат бус байдалд алдагдах нөхцөл байдал үүссэн тохиолдолд тухай бүр ТУЗ-ийн даргад мэдэгдэх;
  - 5.2.9. ТУЗ-ийн даргын ажлын гүйцэтгэлийн үнэлгээг бусад ердийн болон хараат бус гишүүдийн саналыг авсны үндсэн дээр хариуцан гүйцэтгэх;
  - 5.2.10. ТУЗ-ийн хараат бус бүх гишүүд хагас жил тутам 1 (нэг)-ээс доошгүй удаа бие даан, тусдаа хуралдаж, тухайн хурлаар хэлэлцэх асуудлыг хоорондоо болон ТУЗ-ийн даргатай зөвлөлдөн тодорхойлж, хараат бусаар хэлэлцэх;
  - 5.2.11. Комплайнсийн хяналтын чиг үүрэг хариуцсан нэгжийн тайланг энэ журмын 5.2.10 дахь хэсэгт заасны дагуу хараат бусаар хэлэлцэн, санал, зөвлөмж, дүгнэлт гарган ТУЗ-ийн хуралд хэлэлцүүлэх.
- 5.3. ТУЗ-ийн гишүүний бүрэн эрх дараах тохиолдолд дуусгавар болно. Үүнд:
- 5.3.1. Чөлөөлөгдөх хүсэлт гаргасныг ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн /энэ тохиолдолд хүсэлтээ 1 (нэг) сараас доошгүй хугацааны өмнө ТУЗ-ийн даргад бичгээр мэдэгдэнэ/;
  - 5.3.2. 3 (гурав)-аас дээш сараар бүрэн эрхээ хэрэгжүүлэх чадваргүй болсон;
  - 5.3.3. Эрүүгийн гэмт хэрэг хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлсэн;
  - 5.3.4. Нас барсан;
  - 5.3.5. Хууль тогтоомжид заасан бусад;
- 5.4. ТУЗ-ийн гишүүн нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 3 (гурав) болон түүнээс дээш удаа хуралд дараалан оролцоогүй тохиолдолд ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлөх асуудлыг ТУЗ хэлэлцэж болно.

### **ЗУРГАА. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ**

- 6.1. ТУЗ-ийн үйл ажиллагаа явуулах хэлбэр нь ТУЗ-ийн хурал байх бөгөөд ТУЗ-ийн хурлыг танхим, цахим, хосолсон /танхим, цахим/ хэлбэрээр зохион байгуулж болно.
- 6.2. ТУЗ-ийн хурлаар хууль тогтоомж болон банкны дүрэмд заасан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.
- 6.3. ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх буюу танилцуулах асуудал /цаашид "хурлын материал" гэх/-ыг банкны гүйцэтгэх удирдлага доор дурдсан иж бүрдлийг ханган ТУЗ-ийн нарийн бичгийн даргад сар бүрийн 10-ны өдрийн дотор, эсхүл хурлын тов зарлагдахаас 4 (дөрөв)-өөс доошгүй хоногийн өмнө ирүүлнэ. Үүнд:
  - 6.3.1. Гүйцэтгэх захирал, эсхүл эрх бүхий этгээдийн шийдвэрээр гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэж буй албан тушаалтны гарын үсгээр баталгаажсан албан хүсэлт;
  - 6.3.2. Хариуцан боловсруулсан ажилтан, асуудал хариуцсан нэгжийн захирал, харьяалах газрын захирал, тэргүүн дэд захирал, эсхүл дэд захирлын гарын үсгээр баталгаажсан танилцуулга;
  - 6.3.3. ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх буюу танилцуулах асуудалд холбогдох мэдээлэл, шаардлагатай бусад баримт бичиг болон шийдвэрийн төсөл цахим болон цаасан хэлбэрээр бүрэн ирүүлсэн байх.
- 6.4. ТУЗ-ийн хурлын материал энэ журмын 6.3 дахь хэсэгт заасан иж бүрдлийг хангаагүй тохиолдолд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хүсэлтийг хүлээн авахаас татгалзаж буцаан шийдвэрлэнэ.

- 6.5. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга энэ журмын 6.3 дахь хэсэгт заасны дагуу ирүүлсэн хурлын материалыг нэгтгэн хэлэлцэх буюу танилцах асуудлын жагсаалтыг гаргаж, хурлын материалыг ТУЗ-ийн даргад танилцуулж, хэлэлцүүлэх асуудалд ТУЗ-ийн дэргэдэх хороодын санал, дүгнэлт, зөвлөмжийг тусгах зорилгоор хороодын хурлыг хуралдуулах, ТУЗ-ийн хурлыг хуралдуулах, хурлын тов тогтоох эсэхийг шийдвэрлүүлнэ.
- 6.6. Банкны үйл ажиллагаанд учирсан эрсдэл, жилийн бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны үр дүн, банкны бүтэц, зохион байгуулалттай холбоотойгоор ТУЗ-ийн хурал хуралдуулах хүсэлт ирүүлсэн тохиолдолд энэ журмын 6.3 дахь хэсэгт заасан хугацааг баримтлахгүйгээр ТУЗ-ийн даргад танилцуулж, ТУЗ-ийн хурлыг хуралдуулах, хурлын тов тогтоох эсэхийг шийдвэрлүүлнэ.
- 6.7. ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга энэ журмын 6.5, 6.6 дахь хэсэгт заасны дагуу хурлын материалыг ТУЗ-ийн даргад танилцуулахдаа хурлын материалд холбогдох танилцуулга, шаардлагатай мэдээлэл, баримт бичиг болон шийдвэрийн төслийг ТУЗ-ийн гишүүдэд цахим хэлбэрээр хүргэх ТУЗ-ийн хурлын мэдээлэл хүргэх цахим мэдээллийн сүлжээнд байршуулсан байна.
- 6.8. Банкны үйл ажиллагаа /бизнес/-ны нууцтай холбоотой тооцоо судалгаа болон бусад бичиг баримтыг урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр ТУЗ-ийн хурлын үеэр гишүүдэд тарааж, танилцуулж болно.
- 6.9. ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга энэ журмын 6.3 дахь хэсэгт заасан хугацаанаас хойш ирсэн хурлын материалыг дараа сарын хурлын материалд нэгтгэн ТУЗ-ийн даргад танилцуулна.
- 6.10. ТУЗ-ийн ээлжит бус хурлыг ТУЗ-ийн дарга, хараат бус гишүүд, гүйцэтгэх захирлын санаачилга, шаардлагаар хуралдуулж болно. Хурал хуралдуулах санал гаргагч этгээд нь саналаа бичгээр мэдэгдэнэ.
- 6.11. ТУЗ-ийн дарга ТУЗ-ийн хурал хуралдуулах шийдвэр гаргахдаа хурлын товыг хурал хуралдахаас 3 (гурав)-аас доошгүй хоногийн өмнө тогтооно.
- 6.12. ТУЗ-ийн даргын тогтоосон хурлын товыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга ТУЗ-ийн гишүүдэд цахим шуудан болон утсаар мэдэгдэнэ.
- 6.13. ТУЗ-ийн гишүүдэд цахим шуудангаар хурлын товыг мэдэгдэхдээ хурлын тов, хурлаар хэлэлцэх асуудал буюу танилцуулах асуудлын жагсаалт, хурлын материалыг байршуулсан ТУЗ-ийн хурлын мэдээлэл хүргэх цахим мэдээллийн сүлжээний хаяг болон шаардлагатай бусад мэдээллийг агуулсан байна.
- 6.14. ТУЗ-ийн даргын шийдвэрийн дагуу ТУЗ эчнээ санал хураалтаар шийдвэр гаргаж болох бөгөөд тухайн асуудлыг хариуцсан ажилтан ТУЗ-ийн нарийн бичгийн даргатай хамтран ТУЗ-ийн гишүүдээс энэ журмын хавсралтаар батлагдсан танилцуулах хуудсаар санал авч, нэгтгэн ТУЗ-ийн даргад танилцуулна.
- 6.15. ТУЗ-ийн хурлаар асуудал хэлэлцэхдээ дараах журмыг баримтална:
  - 6.15.1. ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонх хуралд оролцсоноор хурлын ирц бүрдэх бөгөөд хурлаар хэлэлцэх буюу танилцуулах асуудлыг ТУЗ-ийн дарга

танилцуулж, хэлэлцэх асуудалтай холбогдуулан ТУЗ-ийн гишүүдээс санал авна.

- 6.15.2. ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй боловч цаг үеийн нөхцөл байдлаас хамааран яаралтай журмаар хэлэлцэх асуудлыг ТУЗ-ийн даргын танилцуулснаар ТУЗ-ийн хурлаар нэмж хэлэлцэж болно.
- 6.15.3. Хурлын товд тусгагдсан хэлэлцэх буюу танилцуулах асуудлыг тогтоосон дарааллын дагуу банкны Гүйцэтгэх захирал, түүний эзгүйд Тэргүүн дэд захирал буюу дэд захирал танилцуулах бөгөөд ТУЗ-ийн даргын зөвшөөрлөөр тухайн асуудлыг шууд хариуцах нэгжийн захирал танилцуулж болно.
- 6.15.4. Хэлэлцэх асуудлыг танилцуулж дууссаны дараа хэлэлцэх асуудалд холбогдуулан ТУЗ-ийн дэргэдэх хороодын гаргасан санал, дүгнэлт, зөвлөмжтэй танилцах бөгөөд шаардлагатай тохиолдолд Дотоод аудитын газраас гаргасан санал, дүгнэлт, зөвлөмжийг сонсож танилцана.
- 6.15.5. Хэлэлцэх асуудлыг танилцуулсны дараа ТУЗ-ийн гишүүд зөвхөн хэлэлцэж буй асуудлын хүрээнд холбогдох асуулт асууж, хариулт авна.
- 6.15.6. ТУЗ-ийн гишүүд хэлэлцэх асуудалд холбогдох санал гаргах бөгөөд зарчмын зөрүүтэй санал гаргаж байгаа тохиолдолд гаргасан саналаа томъёолон ТУЗ-ийн гишүүдэд танилцуулна.
- 6.15.7. Хурал даргалагч ТУЗ-ийн гишүүдийн саналд үндэслэн ТУЗ-өөс гаргах шийдвэрийн төслийг томъёолж, ТУЗ-ийн гишүүдэд танилцуулна.
- 6.15.8. Хурал даргалагчийн гаргасан саналын томъёоллоор санал хураана.
- 6.15.9. ТУЗ-ийн хуралд оролцсон саналын эрхтэй гишүүдийн дийлэнх олонхын саналаар хурлын шийдвэр хүчин төгөлдөр болно.
- 6.15.10. ТУЗ-ийн хуралд аливаа асуудлыг шийдвэрлэхэд гишүүн бүр саналын нэг эрхтэй байх бөгөөд саналын эрхээ бусдад итгэмжлэн шилжүүлэх, ТУЗ-ийн дарга, гишүүн бусад гишүүний өмнөөс санал өгөхийг хориглоно.
- 6.15.11. Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хуралд биеэр хүрэлцэн ирэх болон цахимаар оролцох боломжгүй ТУЗ-ийн гишүүн ТУЗ-ийн даргатай урьдчилан тохиролцож, зөвшөөрөл авсны үндсэн дээр хурлаар хэлэлцэх асуудалд бичгээр санал өгч болох бөгөөд энэ тохиолдолд бичгээр өгсөн саналыг ТУЗ-ийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлд хавсаргаж, түүнийг хуралд оролцсонд тооцно. Нэг удаагийн хуралд 3 (гурав)-аас дээш ТУЗ-ийн гишүүний саналыг бичгээр авахгүй бөгөөд ТУЗ-ийн гишүүн дараалан 2 (хоёр)-оос дээш хуралд бичгээр санал ирүүлэхийг хориглоно.
- 6.16. Банкны болон ТУЗ-ийн дотоод асуудалтай холбоотой, тусгайлан тогтоол гаргах шаардлагагүй, түүнчлэн тухайн хурал дээр шийдвэрлэх боломжгүй, дахин тодруулах, нэмэлт судалгаа шаардлагатай асуудлаар “ТУЗ-ийн хурлын тэмдэглэл” хэлбэртэй шийдвэр гаргаж болно.
- 6.17. ТУЗ-ийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хөтөлж, ТУЗ-

ийн гишүүн бүрээр тухайн хэлэлцэж буй асуудлыг дэмжсэн, дэмжээгүй, түдгэлзсэн эсэхийг хурлын тэмдэглэлд тусгана. Хурлын үеэр аудио бичлэгийг бүрэн байдлаар хийж, хадгалах бөгөөд хурлыг баримтжуулах зорилгоор видео техник, тусгайлсан программ хангамж ашиглаж болно. ТУЗ-ийн дарга, гишүүд хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлтэй танилцаж, гарын үсэг зурах бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийн үнэн зөвийг хариуцна. ТУЗ-ийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлд дараах зүйлийг тусгасан байна.

6.17.1. Хурал хуралдсан газар, өдөр, цаг;

6.17.2. Хуралд оролцсон ТУЗ-ийн гишүүд /цахим болон биетээр/, хурлын ирцийн хувь;

6.17.3. Хурлаар хэлэлцсэн асуудал;

6.17.4. Хуралд бичгээр санал ирүүлсэн ТУЗ-ийн гишүүдийн санал;

6.17.5. Хэлэлцсэн асуудал бүрээр ТУЗ-ийн гишүүдийн гаргасан санал, хэлсэн үг, асуулт, хариулт;

6.17.6. Хэлэлцсэн асуудал бүрээр гаргасан шийдвэр, санал хураалтын дүн;

6.17.7. Хэлэлцэх асуудлаар эсрэг саналтай байсан ТУЗ-ийн гишүүдийн санал;

6.17.8. Хуралд оролцсон гишүүдийн гарын үсэг;

6.17.9. Хуралд бичгээр санал ирүүлсэн ТУЗ-ийн гишүүдийн санал.

6.18. ТУЗ-ийн хурлын шийдвэрийг хурал хуралдсан өдрөөс хойш ажлын 2 (хоёр) өдрийн дотор, хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг хурал хуралдсан өдрөөс хойш ажлын 5 (тав) өдрийн дотор ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хариуцан албажуулна.

6.19. ТУЗ-ийн хурлаас гарсан шийдвэрийн нэг хувийг гүйцэтгэх удирдлагад ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хүлээлгэн өгнө. Шаардлагатай гэж үзвэл хурлын шийдвэрийг нийт ажилтнуудад танилцуулж болно.

6.20. Хурлын ирцийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга бүртгэх бөгөөд ирцийн бүртгэлийг ТУЗ-ийн дарга баталснаар ТУЗ-ийн гишүүний цалинг олгох үндэслэл болно.

6.21. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга ТУЗ-ийн хурлын бэлтгэл ажлыг хангаж, зохион байгуулна.

## **ДОЛОО. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТӨЛӨВЛӨХ, ТАЙЛАГНАХ**

7.1. ТУЗ-ийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг ТУЗ-ийн хараат бус гишүүд ТУЗ-ийн даргатай зөвлөлдөн боловсруулж, өмнөх жилийн 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн батлуулна.

7.2. Энэхүү журмын 7.1 дэх хэсэгт заасан үйл ажиллагааны төлөвлөгөөнд ТУЗ-ийн дэргэдэх Засаглалын албаны төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж, батлуулна.

7.3. ТУЗ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг жилийн эцэст ТУЗ-ийн дэргэдэх Засаглалын албанаас нэгтгэн гаргаж, ТУЗ-ийн үйл ажиллагааг үнэлэх журмын дагуу

үнэлж, дараа жилийн эхний улиралд багтаан ТУЗ-ийн хуралд танилцуулна.

- 7.4. ТУЗ-ийн хараат бус гишүүд нь өөрийн ажлын тайланг улирал бүр дараа сарын 15-ны өдрийн дотор эрх бүхий байгууллагаас баталсан журын дагуу гаргаж, Монголбанканд хүргүүлэх бөгөөд хагас жил тутамд олон нийтэд мэдээлнэ.
- 7.5. ТУЗ-ийн хараат бус гишүүд өөрийн оролцсон ХЭХ, ТУЗ-ийн хурал, ТУЗ-ийн дэргэдэх хороодын ажлын тайлангаа хурал болсноос хойш ажлын 14 (арван дөрөв) хоногийн дотор банкны дүрмийн 11.6 дэх хэсэгт заасан хугацаанаас өмнө Монголбанканд хүргүүлнэ.
- 7.6. ТУЗ-ийн гишүүн өөрийн жилийн үйл ажиллагааны тайланг жил бүрийн 01 дүгээр сарын 15-ны өдрийн өмнө ТУЗ-ийн нарийн бичгийн даргад гаргаж өгнө.
- 7.7. ТУЗ-ийн гишүүний жилийн үйл ажиллагааны тайланг холбогдох журмын дагуу үнэлэн, ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланд нэгтгэж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулах бөгөөд ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, банкны цахим хуудсанд байршуулна.

### **НАЙМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНИЙ ЁС ЗҮЙ**

- 8.1. ТУЗ-ийн гишүүн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчийн болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”, “Төрийн банк” ХК-ийн ёс зүйн дүрэм, эдгээрт нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн хүрээнд эрх, үүргээ хэрэгжүүлнэ.
- 8.2. ТУЗ-ийн гишүүн банкны хувьцааг олон нийтэд арилжаалахтай холбогдох үйл ажиллагаа болон банкны эрхэлж буй бусад үйл ажиллагаа, бусад этгээдтэй байгуулах гэрээ, хэлэлцээр, хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрт өөрийн хувийн ашиг сонирхол, хамаарал бүхий этгээд болон нэгдмэл сонирхолтой этгээдээр дамжуулан шууд, шууд бус байдлаар оролцох, оролцож болзошгүй тохиолдолд энэ талаар ТУЗ-ийн даргад нэн даруй бичгээр мэдэгдэж, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу холбогдох арга хэмжээг авна. ТУЗ-д нэн даруй бичгээр мэдэгдэх боломжгүй нөхцөл байдалд ТУЗ-ийн даргад харилцаа, холбооны хэрэгсэл ашиглан яаралтай мэдэгдэх бөгөөд аль болох боломжит богино хугацаанд албан бичгээр мэдэгдлийг хүргүүлнэ.
- 8.3. ТУЗ-ийн гишүүний албан үүрэгтэй холбогдуулан аливаа этгээд бэлэг, үйлчилгээ, ашигтай нөхцөл байдлыг санал болгосон тохиолдолд дараах арга хэмжээг авна. Үүнд:
  - 8.3.1. Саналаас татгалзах;

- 8.3.2. Санал тавьсан этгээдийг тодорхойлох;
  - 8.3.3. Тодорхой нөхцөл байдлын улмаас бэлгийг эргүүлэн өгөх боломжгүй бол бэлгийг хадгалах ба энэ тухай өөрийн удирдах албан тушаалтан, эрх бүхий байгууллагад нэн даруй мэдэгдэх;
  - 8.3.4. Боломжтой бол тухайн үйл явдлын гэрчийг тэмдэглэх;
  - 8.3.5. Болсон нөхцөл байдлын талаарх мэдэгдлээ боломжит хугацааны дотор өөрийн удирдах албан тушаалтан, эрх бүхий байгууллагад бичгээр хүргүүлэх;
  - 8.3.6. Хариуцлага хүлээхээр зөрчил илэрсэн тохиолдолд эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдэгдэж, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу холбогдох арга хэмжээг авна.
- 8.4. ТУЗ-ийн гишүүн банкны нууц мэдээллийн аюулгүй байдлыг хангах, хамгаалахад банкны дотоод журмаар тогтоосон дэгийн дагуу чанд мөрдөнө.
  - 8.5. ТУЗ-ийн хараат бус гишүүд хараат бус байдалд нь нөлөөлөх аливаа үйл ажиллагаанаас татгалзах үүрэгтэй бөгөөд хараат бус байдалд нөлөөлөх, нөлөөлж болзошгүй нөхцөл байдал үүсэж болзошгүй тохиолдолд бол энэ талаар ТУЗ-ийн даргад нэн даруй бичгээр мэдэгдэж, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу холбогдох арга хэмжээг авна.
  - 8.6. Банк, түүний харилцагч болон гуравдагч этгээдийн “нууц” гэж үзсэн аливаа мэдээлэл, дотоод мэдээллийг хувийн ашиг сонирхлын үүднээс ашиглахгүй байх, шууд, шууд бус байдлаар бусдад задруулахгүй байх, гуравдагч буюу хөндлөнгийн этгээдэд дамжуулахгүй байх, ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлөгдсөний дараа 3 жилийн турш энэ хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллана.
  - 8.7. Банкнаас олгосон зээлийн талаарх банк хоорондын мэдээлэл, зээлийн мэдээллийн санд холбогдох хууль, гэрээнд заасны дагуу өгөх мэдээлэл, Банкны тухай хуульд заасан тайлан, мэдээлэл болон банк, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагчийн хооронд солилцсон мэдээлэл энэ журмын 8.6 дахь хэсэгт хамаарахгүй.
  - 8.8. ТУЗ-ийн гишүүн өөрийн болон нэгдмэл сонирхолтой этгээдийн талаарх мэдээллийг ТУЗ-ийн нарийн бичгийн даргад холбогдох журмын дагуу гаргаж өгөх бөгөөд тэдгээрт өөрчлөлт орсон тухай бүр ТУЗ-ийн нарийн бичгийн даргад мэдэгдэнэ.

“Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн  
 ээлжит хурлын 2023 оны ... дугаар сарын ...-ны  
 өдрийн ...дугаар тогтоолын хавсралт

## “ТАНИЛЦУУЛАХ ХУУДАС №

Огноо	20.. оны ... сарын ...-ны өдөр			
Танилцуулах материал	...			
Боловсруулсан нэгж/ ажилтан	...			
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хүлээж авсан огноо	20.. оны ... сарын ...-ны өдөр			
Материалын иж бүрдэл	- ... - ... - ... - ...			
<input type="checkbox"/> ТУЗ-ийн хурлаар шийдвэрлэх эсэх		<input type="checkbox"/> Ажлын шугамаар шийдвэрлэх		<input type="checkbox"/> ТУЗ-д танилцуулах
д/д	Танилцсан гишүүн	Огноо	Санал/ тэмдэглэл	Гарын үсэг
1	ТУЗ-ийн дарга			
2	ТУЗ-ийн гишүүн			
3	ТУЗ-ийн гишүүн			
4	ТУЗ-ийн гишүүн			
5	ТУЗ-ийн гишүүн			
6	ТУЗ-ийн гишүүн			
7	ТУЗ-ийн хараат бус гишүүн			
8	ТУЗ-ийн хараат бус гишүүн			
9	ТУЗ-ийн хараат бус гишүүн			

## **“ТӨРИЙН БАНК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ ТӨСӨЛ**

### **“Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалт, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.9 дэх заалт, “Төрийн банк” ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5.18 дахь заалт, “Төрийн банк” ХК-ийн 2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Төрийн банк” ХК-ийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан “Төрийн банк” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 01/1 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

3. “Төрийн банк” ХК-ийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын хэрэгжилтийг ханган ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /Б.Тэлмүүн/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

С.МӨНГӨНЧИМЭГ



## САНАЛЫН ХУУДАСНЫ ЗАГВАР

“Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
2023 оны ...3 дугаар сарын ...17-ны өдрийн ...77 дугаар  
тогтоолын ...4 дугаар хавсралт



### “ТӨРИЙН БАНК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС

Хувьцаа эзэмшигчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр: \_\_\_\_\_

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар: 

--	--	--	--	--	--	--	--	--	--

Хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар: 

--	--	--	--	--	--	--	--	--	--

Эзэмшиж буй хувьцааны төрөл: энгийн

Эзэмшиж буй хувьцааны тоо: \_\_\_\_\_

“Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 10 цагт хосолсон /танхим, зайнаас/ хэлбэрээр зохион байгуулагдана.

№	Хэлэлцэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	“Төрийн банк” ХК-ийн 2022 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батлах тухай тогтоолын төсөл			
2	“Төрийн банк” ХК-ийн хувьцааг нэмж гарган олон нийтэд санал болгох тухай тогтоолын төсөл			
3	“Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журамд өөрчлөлт оруулах тухай тогтоолын төсөл			
4	“Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын журам батлах тухай тогтоолын төсөл			
5	“Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ажиллах журам батлах тухай тогтоолын төсөл			

2023 оны ... –р сарын ...-ны өдөр

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг, гарын үсгийн тайлал: \_\_\_\_\_  
/ \_\_\_\_\_ /

Саналын хуудсыг бүртгэж, хүлээж авсан ажилтны гарын үсэг, гарын үсгийн тайлал: \_\_\_\_\_  
/ \_\_\_\_\_ /

**САНАМЖ**

1. Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт (✓) тэмдэглэгээг хийнэ үү.
2. Хувьцаа эзэмшигч Та саналаа урьдчилсан байдлаар цаасан хэлбэрээр өгөх бол өөрийн үйлчлүүлдэг брокер, дилерийн компаниар дамжуулан эсвэл Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо 7/1 хаягт байрлах "Төрийн банк" ХК-ийн Төв байр, орон нутаг дахь салбар нэгжүүдээр, цахим хэлбэрээр өгөх бол Төрийн банкны цахим хуудас /[www.statebank.mn/](http://www.statebank.mn/)-аар дамжуулан өгч болно.
3. Хувьцаа эзэмшигч Та урьдчилан санал өгсөн бол дахин санал өгөх эрхгүй.
4. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэн санал өгч байгаа бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч нотариатаар баталгаажуулж, итгэмжлэлийн хамт хүчинтэйд тооцно.
5. Засварласан, балласан, залруулгатай саналын хуудас нь хүчингүйд тооцогдоно.
6. Хэлэлцэх асуудалтай холбогдох асуулт, саналаа арын нүүрэнд бичиж өгнө үү.

Энэ хэсгийг хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комисс бөглөнө.

Саналын хуудсыг хүчинтэйд тооцох эсэх: Тийм/Үгүй

Тооллогын комиссын даргын гарын үсэг, гарын үсгийн тайлал:  
\_\_\_\_\_/\_\_\_\_\_/

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон бол түүний шалтгаан:

—oо—

Хувьцаа эзэмшигчийн асуулт, санал:

---

---

---

---

---

---


---

---

---

---





📞 1800-1881

🌐 [www.statebank.mn](http://www.statebank.mn)

📘 /StatebankMN

📺 /StatebankMN